



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-16

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	7-10
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
09 дүгээр сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга М.Мандхай ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Л.Мөнхбаясгалан;
Чөлөөтэй: Б.Батцэцэг, Б.Бейсен, Д.Жаргалсайхан, С.Одонтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Р.Ренчинбазар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер А.Цогбаяр, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын мэргэжилтэн Р.Хангал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Санхүү, төсвийн судалгааны хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга В.Содномдаржаа, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн сайдын зөвлөх Х.Ганцог, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Намхайхрэнчин, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү,

хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ч.Чулуунчимэг, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Дэчин, Усны газрын дарга З.Батбаяр, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Цаг уур, орчны шинжилгээний газрын Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, М.Ганхүлэг, Б.Уянга, Н.Наранбаатар, Н.Алтаншагай, Ц.Туваан, С.Замира, П.Батчимэг, Г.Ганбаатар, М.Мандхай нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Г.Ганбаатар, О.Алтангэрэл, Б.Жаргалан нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

М.МАНДХАЙ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 13 цаг 25 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

М.Мандхай: Эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Мөнгөнцогийн Ганхүлэг, Мэндбаярын Мандхай, Нанзадын Наранбаатар, Агваанлуvsсангийн Ундраа, Очирбатын Амгаланбаатар, Сонгбайн Замира, Цагаанхүүгийн Мөнхбат, Ухнаагийн Отгонбаяр, Болдын Уянга, Пүрэвийн Батчимэг, Сүрэнжавын Лүндэг, Тогтмолын Мөнхсайхан, Ренчинбямбын Сэддорж, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүд ирсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг эхлэх гэж байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёо. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

ХХААХҮ-ийн сайд Идэрбат, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ууганбаатар, Төсвийн тогтвортой байдлын гишүүн Ренчинбазар, Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч Цэдэнжав, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэлмаа, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Баттуяа, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Цогбаяр, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Мягмардорж, ТНБД Санжаадорж, Сангийн сайдын зөвлөх Ганцог, Татварын бодлогын дарга Чимидсүрэн, Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Содномдаржаа, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ичинноров, Төсвийн орлогын хэлтсийн дарга Гантулга, Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Алтантуяа, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын

газрын мэргэжилтэн Хангал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Гантулга, Байгаль орчин, уур амьс, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Намхайренчин, ТЗУГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Чулуунчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах шинжээч Дэчин, Усны газрын дарга Батбаяр, Ойн газрын дарга Оюунсанаа, ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх газрын дарга Оюунжаргал, ХХААХҮЯамны ТНБД Жамбалцэрэн, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Болорсүх. Эдгээр ажлын хэсгийн гишүүд ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуулт асууж, үг хэлж болно оо гэж заасан.

Ингээд Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн талаар асуух асуулттай гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү.

Ганхүлэг гишүүнээр тасалъя. Отгонбаяр гишүүнийг нэмээд өгөөрэй. Ганхүлэг гишүүн. Ирцээрээ Отгонбаяр гишүүн асуултаа асууя.

У.Отгонбаяр: Та бүгдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн тодотголыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд өнөөдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээрх хэлэлцүүлэг дээр бас нэг ганц нэг зүйл тодруулъя аа.

Энэ төсвийн тодотголын одоо бас нэг том бүрэлдэхүүн хэсэг стратегийн зарим барааны нөөц хангамжийг тогтворжуулна гэж 150 тэрбум төгрөг орж байгаа. Тусгагдаж байгаа. 100 мянган тонн улаан буудайн нөөц бүрдүүлнэ. Хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 12 мянган тонн хүнсний ногоо, махны нөөц дээр 20 мянган тонн зоорь агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулагдсан 20 мянган тоннын зоорь агуулах, тэгээд шатахууны нөөц 299725 мянган куб гэсэн ийм 5 ажилд, 5 зүйлд 150 тэрбум төгрөг зарцуулагдахаар тусгагдсан байна аа.

Энэ маань яг ямар цаг хугацаанд хэрвээ асуудал хүндэрвэл 1 дүгээрт миний асуудал. Би тодорхой асуултууд л асууя.

Нэгдүгээрт эдгээр нөөц маань ямар цаг хугацаанд хэрвээ асуудал байдал хүндэрвэл хэчнээн хоногийн нөөц болж чадах вэ? 1 дүгээрт.

Хоёрдугаарт, Нийслэлд нийслэл дээр махны нөөц хавартаа бэлддэг. Хаварт зориулж. Энэнд үндсэндээ нэг 10 гаран тэрбум төгрөг олгогдож байгаа. Энийг жоохон ахиухан шиг болгоод татаас хэлбэрээр биш энэ хөрөнгөөр нь өөрөө мах бэлдэж тэр хомсдол үүссэн үед нь үнэ ханш өссөн үед нь хямд үнээр гаргах ийм бодлого бас хэрэгжүүлж хэрэгжүүлбэл яадаг юм бэ? Энэ дээр ер нь яам ямар бодлоготой байгаа вэ гэж.

Гуравдугаарт, эдгээр стратегийн нөөц бүрдүүлснээр инфляцад эерэг нөлөө хэр үзүүлэх вэ? Яагаад би энийг асууж байна гэхээр хагас жилийн байдлаарх инфляц 13 хувьд хүрсэн байгаа. Үндсэндээ энэний 50 орчим хувь нь мах, улаан

буудай, төмс, хүнсний ногоо гэсэн эдгээр зүйлээс хамаарсан ийм инфляц байгаа гэж танилцуулсан.

Тийм учраас эдгээр стратегийн зарим барааны нөөц хангамжийг тогтворжуулах чиглэлд тавигдаж байгаа энэ мөнгөн дүн маань инфляцад эерэг хэр эерэг нөлөө үзүүлэх вэ? Энэ дээр бас нэг мэдээ мэдээлэл өгөөч гэсэн ийм 3 асуулт байна.

М.Мандхай: Хэн хариулах вэ? ХАА-н сайд.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Монгол Улсын 2026 оны төсвийн тодотгол дээр 1.4 их наяд төгрөг төсвийн тодотголд тусгагдаад үүний бараг арваад хувь нь болох 150 орчим тэрбум төгрөг энэ ХАА-н салбар, энэ хүнсний салбарт зориулагдаж байгаа. Шалтгаан бол инфляцад хүчтэй нөлөө үзүүлж байгаа энэ хүнсний бараа бүтээгдэхүүн, тэр дундаа стратегийн бараа бүтээгдэхүүн нөгөө талдаа. Бас дотооддоо бид инфляцыг тодорхой хэмжээнд зохицуулаад бариад байх боломжтой энэ бүтээгдэхүүнүүд рүүгээ бас нөөц бүрдүүлэх ийм зүйл.

Хоёр дахь учир шалтгаан бол бас энэ геополитикийн хүнд нөхцөл цаг үед Монгол Улсын стратегийн хүнсний нөөцийг бас баталгаатай хангах гэсэн үндсэн гол 2 агуулгаар энэ төсвийн тодотголд туссан байгаа. Отгонбаяр гишүүн тодорхой асууж байна. Энэ 5 төрлийн зүйл байгаа. Улаан буудайн стратегийн нөөц бол бид 100 мянган тонн орчмыг бүрдүүлнэ. Энэ бол Монгол Улсын гурилын хэрэгцээний 3-ны 1-ийн шаардлагатай будааны нөөцийг бид бүрдүүлнэ.

Хоёрдугаарт, бид гурилын үйлдвэрүүд 9 гурилын үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ үйлдвэрүүд дотоодын улаан буудайгаараа үйлдвэрлэлээ тасралтгүй явуулахад шаардлагатай байгаа хөрөнгийн эх үүсвэрийг бас үүгээр шийдвэрлэж байгаа. Хүнсний ногооны асуудал бол бас ер нь бараг анх удаа шахуу ийм зүйл. Тэгэхээр энэ хүнсний ногооны багтаамж зоорины бэлтгэлүүд ер нь хангагдаж байна. Өнөөдрөөс бид бол энэ худалдан авах нээлттэй байх энэ журам юмнуудаа бас боловсруулаад батлагдаж байна. Шатахуун юмнуудыг Төв аймгийн Борнуур, Жаргалант, Угтаал гээд ингээд хүргүүлээд ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр эндээсээ бид бол энэ 30.7 тэрбум төгрөгөөр 12-оос 13 мянган тонн төмс хүнсний ногоо зоорилно гэж үзэж байгаа.

Дараагийн ээлжид энэ ургац хураалтад шаардлагатай байгаа шатахууны нөөц одоо бид энэ 2500 тонныг өнөөдрөөс түгээж эхэлж байна. Дахиад 5 мянган тонныг бид нөөцөлнө. Үлдсэн нь бол хаврын тариалалтад хэрэглэгдэнэ гэж ингэж үзэж байна.

Дараагийн зүйл бол нийслэлийн махных байгаа юм аа. Тэгээд эдгээр бүх зүйлүүд бол энэ 5 тавигдсан энэ зарцуулалт бол 1 дүгээрт гурилын хангалтын 30 хувийг жилийн хэрэглээний 30 хувийг даах хэмжээний улаан буудайг бид нөөцөлж байна. Төмс, хүнсний ногоо, мах бол улирлын чанартай. Энэ ингээд өнгөрсөн хавраас ингээд харж байхад хавар 5 сараас эхлээд л төмсний үнэ өсөөд л 7 сар гаргаад л наадмын ар дээр ид аялал зугаалгын үеэр төмсний үнэ хаданд гардаг. Тэр нь дандаа импортын төмснүүд байгаад байдаг. Тэгэхээр энэ үед бид нар нөгөө

төмсний хүнсний ногооны зах зээл рүү энэ төмсийг оруулна. Энийг бид бас жижиг хэмжээнд туршиж үзсэн амжилттай байна гэж ингэж дүгнэсэн.

Тийм учраас энэ орж байгаа.

Тэгэхээр энэ бол нөгөө нэг жилийн хэрэгцээний тэдэн хувь.

М.Мандхай: Минут нь дууслаа гүйцээж авах уу, гүйцээгээд авъя.

Ц.Идэрбат: Тэдэн сарын гэхээсээ илүү инфляцад нөлөөлж эхлэх тэр мөчлөгүүдийн үед гаргана гэсэн ийм үг. Махан дээр олон жил явж ирсэн л ийм үйл явц. Энэ дээр бол одоо Отгонбаяр гишүүнтэй зарим нэг зүйл дээр санал нэг байна. Энийг арай өөр түвшинд зохион байгуулах саналыг нийслэл боловсруулаад бэлэн болгочихсон байгаа. Гэхдээ бид бол цаг хугацаа тулчихсан байгаа энэ үед энэ жилдээ уламжлалтаараа явъя. Ирэх жилээс бол нийслэл өөрөө энийгээ менежментээ хийгээд энэ сүлжээ дэлгүүрүүдтэйгээ хамтраад явах маш том зураглалыг гаргачихсан ийм байдалтай байгаа.

Тэгэхээр энэ жилийн хувьд бол мөн мах бол бас л ялгаагүй өчигдөр Ерөнхий сайд ярьсан. Бид 15-20 мянган тонн нөөцийн махыг бэлтгэж 3 сарын 15-аас 6 сарын 15 цаашлаад 7 сарын 1-ний хооронд зарцуулна. Тэгээд энэ бүх зүйлүүд бол нөгөө хяналтын систем, агуулахын хяналт гэдэг энэ зүйлийг л бүгдийг нь нэвтрүүлэх.

М.Мандхай: Тодруулъя.

У.Отгонбаяр: Тийм бас сайдтай санал нэг байна аа. Энэ махны нөөц бүрдүүлэх энэ арга механизмыг арай өөр чиглэл рүү арай арга хэлбэрийг нь арай өөрчлөх ийм зайлшгүй шаардлага байгаа юм билээ.

Тийм учраас энэ жилдээ уламжлалт аргаараа явах юм байна гэж ойлголоо. Ирэх жилээс арай өөр хэлбэр рүү зайлшгүй орох шаардлага байгаа гэдгийг өөрөө цаг хугацаа бидэнд энэ өнгөрсөн цаг хугацаа бидэнд бас харууллаа гэдгийг хэлье.

Дараагийн нэг тодруулах асуудал энэ зоорины хүчин чадал ер нь яг өнөөгийн түвшинд ямар байгаа юм бэ? Хувь хувьсгалын түвшинд. Тэгээд 20 мянган тонн зоорь шинээр бий болоход ямар бас ахиц дэвшил гарах байгаа талаар бас нэг мэдээлэл өгөөч.

М.Мандхай: Идэрбат сайдын микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Монгол Улсад хамгийн сүүлд Атрын 4 дүгээр аяны хүрээнд бас хөнгөлөлттэй зээл олгогдсоноор 14 мянган тонн зоорь ингээд багтаамж нэмэгдээд ингээд явж байгаа. Бид цаашлаад АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн ангилалд энэ хүнсний ногоо, махны зоорины асуудлыг бас оруулна. Гэхдээ өнөөдрийн энэ төсвийн тодотгол дээр яригдаж байгаа энэ мах, энэ ногоо, энэ бүх нефть гээд энэ бүх зүйлүүдийг бол нөөцлөхөд сав суулга, зоорь бүх зүйлүүд бэлэн байдлаа хангачихсан ингээд явж байгаа. Нефтийн хувьд бид 7.5 мянган тонн багтаамжтай савандаа ер нь 3-ны 1-ийг нь авчхаад байна. Энэ төсвийн тодотгол хэрвээ батлагдвал бид ингээд бараг 70 хувьд нефть авчихна. Хүнсний ногооны хувьд бол энэ ААН-үүд хувь иргэдийн барьсан яг технологийн зоориуд газар зоорь биш энэ чинь төмс нь өөр зооринд, саримс нь өөр зооринд орох ийм технологитой учраас яг

тэрэндээ зориулсан зоорины бэлтгэл бэлэн байдлыг хангаад байгаа. Ер нь хөнгөлөлттэй.

М.Мандхай: Нэг удаа тодруулъя.

У.Отгонбаяр: Ер нь цаашдаа ХХААЯ энэ ард иргэд өрх гэрийг зорьжуулах тийм томоохон хөтөлбөр зүгээр хэрэгжүүлмээр санагддаг юм. Зоорийг зөвхөн улс, том ААН-үүд зорь хийдэг биш айл өрхүүд өөр өөрсдийнхөө хэрэгцээнд зориулсан төмс, хүнсний ногоо хадгалах, тэрийгээ нөөшлөх, даршлах, дарсан ногоогоо хадгалах, энэ чиглэлийн бас томоохон хөтөлбөр ер нь алсдаа хэрэгжүүлэх зайлшгүй бас шаардлага байгаа юм байна лээ шүү.

Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ дээр бас анхаарч ажиллахыг бас хүсье ээ.

Мөн энэ нөөц бүрдүүлэх худалдан авалт дээрээ бас онцгой анхаараарай. Энэний чанар чансаан дээр бас онцгой анхаараарай. Баахан зүйл худалдан авалт хийдэг, дараа нь чанар, чансаа.

М.Мандхай: Үг хэллээ. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе.

2026 оны төсөв дээр тодотгол хийх асуудал бас яригдаж байна.

Тодотголд тусгагдаагүй 2 асуудлаас эхэлье гэж бодож байна. Байнгын хороо бас өөрсдийн нэгдсэн байр суурьтай бас болох ёстой юм уу? Ямар аргаар бас хэдүүлээ бас саналаа уламжлах ёстой юм бол оо. 2024 оны 6 сард бид батлаагүй л дээ. Олон сонгогдсон одоо бас зарим сайд энэ тэр хийж байгаа бас гишүүд маань өөрсдөө баталсан. Малчны тухай хууль гэж бас их сайхан нэртэй хуулийг батлаад өнөөдрийг хүртэл хэрэгжилт нь бүрэн дүүрэн байж чадахгүй байна гэдэг үнэлэлтүүдийг малчид маань иргэд маань бас өгсөөр байна аа. Тэгээд аргаа бараад сая сонсгол хийсэн. Баахан олон малчдыг газар газраас нь авчирч байгаад л бас энэ танхимд сууж байгаад л бид нар баахан ярьсан.

7 сарын 2-ны өдөр Засгийн газарт бид нар тогтоолоор маш тодорхой чиглэлийг хүргүүлсэн байгаа. Тэгээд энэ дунд байгаа хамгийн их яригдаад байгаа НДШ-тэй холбогдолтой асуудлыг тодотгол дээр орж ирэх болов уу? 2027 оны төсөв дээр орж ирэх болов уу гэж олон малчид харж байгаа. Тэгээд энэ талаар ер нь Засгийн газар яг ямар байр суурьтай байгаа юм бэ? Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамныхан энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ. Энийг оруулъя гэхээр хэдэн төгрөгийн зардал, санхүүгийн асуудал цаана нь байгаад байгаа юм. Ямар асуудал байгаад байгаа учраас бид нар шийдэж чадахгүй байгаад байгаа юм бэ гэдгийг тодруулж асууя.

Хэмнэлтийн асуудал хүнд байна, сайд нарын багцаас мөнгө төгрөг хасахад хэцүү байна л гээд байсан. 400 хэдэн тэрбумаар нь хасаад л ороод ирж болдог л юм байна шүү дээ. Шийдье гэж бодож байгаа асуудлаа шийдээд явж бас болдог л юм байна шүү дээ. Тэгээд үнэхээр бас амлалт өгчихсөн хууль нь батлагдчихсан сонсгол хийгээд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм байна гэдгээ гаргаад өгчихсөн асуудлаа ингээд нэг мөр болгоод явж болдоггүй юм уу? Яг одоо нийтдээ

малчдын энэ асуудлыг шийдэхэд хэдэн төгрөг төсөв байгаад байгаа учраас төсөв дээр дарамт болоод байгаа учраас бид хэд ингээд энэ асуудлыг шийдэхгүйгээр тойроод яваад байна вэ гэдгийг эхлээд тодруулж асууя аа.

Боловсролын яамныхан байвал тэр малчдын хүүхдийг сургах асуудлыг шийдэж байна уу нэг журам батлаад малын эмчээр болон бусад чиглэлээр сургая гэж бодоод байсан тэр чиглэлийн агуулгууд нь орж байна уу гэдгийг би дахиад нэмээд тодруулъя.

Сайд нарын багцаас 433 тэрбум төгрөгийг хассан байна. Тодорхой бас зорилт хөтөлбөрүүд тэр чинээгээрээ бас хэрэгжихгүй болох ийм эрсдэлүүд бас байгаа. Манай энэ Байнгын хорооны харьяа Байгаль орчин болон ХАА-н сайд нарын багцаас ямар ямар төслүүд юу юу хасагдсан бэ гэдгийг тодруулъя.

Эдгээр ажлуудыг бас цааш нь үргэлжлүүлэх чиглэл дээр ямар ажлууд явах вэ? Тэр дундаа Шинэ хоршоо гэдэг энэ хөдөлгөөнийг л ерөөсөө нэг байнгын л ад үзэх юм. Олон мянган малчид нийлээд нэгдээд зохион байгуулалтад ороод явж байгаа энэ хөтөлбөрөө үргэлжлүүлээд эрчимжүүлээд явах чиглэл дээр энд тодотгол болон төсөв дээр яригдаж байгаа бодож байгаа зүйлүүд бас байна уу? Энийг та бүхэн маань бас нэг анхаараад нэг тодорхой хариулт өгөөч гэдгийг бас хэлье. Сая Отгонбаяр гишүүн маань бас асуулаа. ХАА-н салбар дээрх орж ирж байгаа нэмэлтээр орж ирж байгаа энэ 150 орчим тэрбум төгрөгийн зарцуулалт дээр бид бүхэн онцгой анхаарах ёстой байна аа. Энэ инфляц болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг буулгахтай холбогдолтой тодорхой зорилго хэрэгжих юм байна гэж ойлгож байна. Өмнөх өмнөх энэ урамшуулал татаасуудын бас сонсгол удахгүй бас хийх гэж байна. Тэгээд эндээс ингээд харахаар цөөн хүрээний бас хүмүүс л авсан ийм дүр төрхүүд харагдах нь ээ.

Тэгэхээр яг энэ 150 орчим тэрбум төгрөгийг 4, 5 төрлөөр хуваарилахдаа бүсийн эгэл жирийн жижиг, дунд бизнес эрхэлж байгаа, ногоо тарьж байгаа, МАА эрхэлж байгаа иргэд малчид, үйлдвэрлэгч нарт ямар байдлаар зарцуулах вэ хэн шийдвэр гаргах вэ банкаар дамжих юм уу, яам гаргах юм уу ямаршуу нөхцөлөөр энийгээ бас олгох вэ? Энэ хоршоодыг дэмжих.

М.Мандхай: Эхлээд Сангийн яам хариулъя. Нэг номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Малчны тухай хууль бол 2024 оны 6 сарын 5-ны өдөр батлагдсан. Ингээд энэ хууль дээр 4.2.9 дээр хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчин тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх гэж ингэж ерөнхий байдлаар орсон. Гэхдээ энэ хуулийнхаа 16.1 дээр энэ хуулийн 4.2-ын есөд заасан заалтыг 2026 оны 1 сарын 1-ний хүртэл дагаж мөрдөнө өө гэсэн ийм заалттай, ийм хууль батлагдаад мөрдөгдсөн. Өөрөөр хэлбэл энэ 2026 оны 1 сарын 1 хүртэл ингээд жил хагасын хугацаанд бол журам нь батлагдах ёстой байсан. Журам батлагдсан тохиолдолд бол бид холбогдох зардлыг бол ингээд төсөв дээр бол тавиад явах ийм зохицуулалт байсан. Одоогийн байдлаар энэ хуулийн дагаж мөрдөх хугацаа дуусчихсан байгаа юм. Ер нь ямар хэмжээний зардал гарах гээд, орох гээд байсан бэ гэдгийг та асууж байна.

Нөхөн төлүүлэхэд бол мэдээж хэрэг эхний удаадаа орлого орж ирнэ. Малчид нөхөн төлүүлээд нэг удаадаа НДШ төлөхөд ойролцоогоор 30 тэрбум төгрөг орно оо

гэсэн НДЕГ-ын тооцоо байдаг юм байна лээ. Гэхдээ дараа жилээс нь эхлээд жил болгон зарлага нь 130 тэрбум төгрөгөөс эхлээд дээшээгээ ийм зардал жил болгон гарч ирэхээр бол ийм тооцоо байсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас өгч байгаа тайлбартаа бол юу гэж байна гэхээр илүү олон жил тогтвортой НДШ-ээ төлсөн байвал илүү өндөр тэтгэвэр ялангуяа суурь тэтгэвэр авдаг байх ийм концепц руу явж байгаа гэж бид бол ойлгоод байгаа.

М.Мандхай: Дараагийнх нь Боловсролын яам. Боловсролын яамнаас байхгүй тэ? ХААЯ-аас хариулъя. Идэрбат сайд хариулна уу?

Ц.Идэрбат: Манай ХААЯ-аас энэ 5 төрлийн энэ төсвийн тодотгол дээр тусгагдсан энэ зүйлүүд зөвхөн нэг жилд ингээд худалдан аваад ингээд байхгүй болчих зүйл огт байхгүй. Жишээ нь стратегийн улаан буудайн нөөц чанартай байгаад эргээд гурилын үйлдвэрт очоод гурил болоод эргээд мөнгө болоод л ороод ирнэ. Энэ нефть мөн ялгаагүй мөнгө болоод л ороод ирнэ. Энэ хүнсний ногоо хэрэгтэй үед нь гаргаж борлуулаад дахиад мөнгө болоод ороод ирнэ. Тэгэхээр өнөөдрийн энэ 2026 оны төсвийн тодотгол дээр тавигдсан 150 тэрбум төгрөг бол энэ газар тариалангийн салбарт хаврын тариалалт намрын тариа хураалт түүний ар дээрх борлуулалт гэдэг зүйл борлуулалт дээр дэмжлэг байхгүй байсан зүйлийг л хөдөлгөөнд оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр тариаланчид энд маш дуртай байгаа. Нөгөө талдаа ил тод байх хуулийн хүрээнд байх нэг компаниас хэт ихийг авахгүй байх. Хүнсний ногоон дээр бол яг энэ хүнсний ногоог нуруун дээрээ үүрээд явж байгаа энэ Борнуур, Жаргалант, энэ Хушаат энэ хавийнхан гээд эд нараасаа эд нар бид ингээд түлхүү Сэлэнгээс гээд ингээд түлхүү авъя гэсэн.

М.Мандхай: Нэмээд хариулчихъя. Тэгээд бас Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой төсөвт суугдсан эсэхийг түрүүн Сангийн яам дутуу хариулсан.

Дээрээс нь тэр малчны хүүхдийг сургах асуудал дээр төсөвт тодорхой шийдэл орсон байгаа юу гэдэг дээр бас нөхөөд хариулаад өгчхөөрэй. Идэрбат сайдын микрофоныг нээе гүйцээж хариулъя.

Ц.Идэрбат: Тэгэхээр энэ худалдан авалтын чанар, худалдан авалтын хамрах хүрээ, энэ бүх зүйлүүдийг бид маш нээлттэйгээр ингэж гаргаж байна. 1 компаниас энэ 100 мянган тонноосоо нэг компаниас хэт ихийг авах ч байдаг юм уу ийм байдлаар биш. Нөгөө талдаа хүнсний ногооныхны хувьд бол яг тарьсан талбай дээр тарьсан ийм хүмүүсээсээ газартай эсвэл газар түрээсэлж тарьсан ийм нийтлэг хүмүүс энэ дүүрэн байгаа учраас энэ хүмүүсээсээ авна. Чанарын хувьд бол хадгалалт даах Монгол Улсын холбогдох стандартыг хангаж байгаа энэ юмнуудаа л авна.

Тэгэхээр энэ чинь нөгөө эргээд борлуулалтад очих учраас чанар энэ юман дээр нь анхаарна аа. Худалдан авалт бол ард нь янз янзын юманд агуулах тийм хардлага, сэрдлэг гарахаар хэмжээнд байхгүйгээр ил тод байна аа. Журам нь ТУЗ-өөрөө өнөөдөр бараг батлагдаж байгаа гэж хэлж болно оо. Баярлалаа.

М.Мандхай: Нэг номерын микрофоныг нээе. Гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад нэмж тайлбар өгье өө.

Хоршооны татаас бол 2026 оны тодотгол дээр 75.9 тэрбум төгрөг байгаа. Батлагдсан дүнг бууруулаагүй. Өөрөөр хэлбэл өмнө нь авчихсан хүмүүсийн нөгөө зээлийн үргэлжилж байгаа тэр хугацаан дахь бол зээлийн хүүгийн татаас байж байгаа гэсэн. Тэр хүмүүс дээр зээлийн хүү нь нэмэгдэх тийм бол эрсдэл байхгүй байгаа.

Дараагийн ээлжид болохлоор Малчны тухай хуулийн 4.2.5 дээр малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг МАА тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад үнэгүй сургах ийм зохицуулалт байгаа. Энэ агуулгаар бол бид нар бол Боловсролын яаман дээр бол энэ дээр журам батлагдах ёстой. Гэхдээ нөгөө талдаа бас нөгөө тэргүүлэх чиглэлийн мэргэжил дээр бол эрэлттэй мэргэжлийн чиглэл дээр энэ өөрөө бас давхцаад орж байгаа учраас сураад явж байгаа. Яг энэ чиглэлээр.

М.Мандхай: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний микрофоныг нээе, тодруулъя.

М.Ганхүлэг: Журам батлагдаагүй нь малчдын буруу биш л дээ. Тэгээд ингээд бид нар өөрсдийнхөө ажлыг хийгээгүй ажлаа ингээд журмаас болоод би уул нь олгох гэж байсан юм шиг юм яриад байх юм. Яах вэ байгаа яг тодорхой мэдээлэл юмнуудаа дүн шинжилгээ хийгээд энэ асуудал нь төсөв дээр хүндрэлтэй байгаа юм гэдгээ хагалаад, хэлээд тэгээд энийг нэг талдаа гаргахгүй бол ингээд бид бас ингээд яг ингээд нэг малчдынхаа өмнө очоод л худлаа үнэн ярьдаг болж байгаа бүтэж байгаа гэдэг, хурал зөвлөгөөн сонсгол хийгээд ямар ч үр дүн байдаггүй. Тэгээд журмынхаа төсөлд энэ асуудлуудаа оруулж ирээгүй хүнтэйгээ тэгвэл хариуцлага тооцох ёстой юм биш үү? Тэгээд энэ нь үндсэндээ хэрэгжээгүйгээр байж энэ хуулийн үндсэндээ заалт нь ингээд хэрэгсэхгүй болчихдог нэг тийм сонин жишгийн тухай л сонсгол дээр ч гэсэн яриад байгаа юм л даа. Тэгээд ийм бас байж бас болохгүй байх аа. Тэгээд энэ тал дээрээ бас та бүхэн маань нэлээн сайн анхаарал хандуулах нь зөв байх гэдгийг би бас нэмээд хэлчихье.

Дахиад нэг байгаа билүү?

М.Мандхай: Нэг минут өгье.

М.Ганхүлэг: Тийм яах вэ сонгон шалгаруулалтын чиглэл дээр хүний оролцоо ямаршуу байх бол? Тэгээд яг яам дангаараа шийдлүүдээ гаргаад явах гэж байна уу? Энэ дээр тодорхой бас сайн зохион байгуулалтуудыг хийх тал дээр бас та бүхэн маань илүү дэлгэрүүлээд бас та нэг хариулт өгөөч гэж.

Хоёр дахь нь болохоор нийт энэ сайд нарын багцаас нэг 433 тэрбум төгрөг хасагдсан гэж байгаа юм. Энэ дунд байгаль орчин болон ХАА-н салбарын сайд нарын багцаас хасагдсан зүйлүүд нь юу юу байгаа вэ? Тэгээд энэнтэй холбогдолтой бас төлөвлөсөн, бодсон ажлууд бас хэрэгжихгүй байх ийм эрсдэлүүд үүсэх үү гэдгийг би асуусан.

М.Мандхай: Сангийн яам нэг номер хариулъя.

М.Санжаадорж: Сайд нарын багцаас бол нийтдээ бол урсгал зардал 433 тэрбум төгрөг хасагдсан байгаа. ХАА-н сайдын багцаас нийтдээ хасагдсан дүн бол нэлээд өндөр тоо байгаа. Би танд харж байгаад хэлье. Гэхдээ нөгөө талдаа бол бас яг инфляцын энэ зорилтот үед бид нар нөөц бүрдүүлэх чиглэлээр бол зардлуудыг

бол нэмж бол тусгасан байгаа. Байгаль орчны сайдын хувьд бол гол ихэнх зардал маань угаасаа өөрөө Копын зардал байсан. Копын зардалтай холбоотойгоор тодорхой хэмжээний зардал бол бас хэмнэгдсэн. Тэр хэмжээгээр бол буурсан. Нөгөө талдаа бол байгаль орчны сайдын багцад бол цаг уурч мэргэжилтэй хүмүүс дээр нь байгаль орчны ажилчдын цалин хөлс бол өөрөө бас нэмэгдэхээр бол орж ирсэн байгаа. Тийм энэ хэмжээгээрээ бол бас нэмэгдэж орж ирсэн. Буурч байгаа дүн нь бол Байгаль орчны сайд дээр 88 тэрбум төгрөг.

М.Мандхай: Хариултаа дахиад гүйцээх үү, гүйцэж авах уу?

Ингээд хасагдсан төсвөөс ямар ямар төслүүд хасагдсан бэ? Жишээлбэл ХХААЯ-ан дээр хөрөнгө оруулалт бараг 37.3 хувь хасагдсан байсан. 82.1-ээс 51.4 болж хасагдсан байсан. Ер нь энэ салбар дундаа хамгийн өндөр хасалттай багц яам байгаа.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой яг ямар ямар төслүүд нь хасагдсан бэ гэдгийг хэлээд өгөөрэй. Нэг номер.

М.Санжаадорж: Дарга сайд нар нь өөрсдөө хариулж болно. Манай дээр хөрөнгө оруулалт бол ийм байгаад байгаа дарга аа. Хөрөнгө оруулалт бол сүүлд батлагдсан хуулиараа төсвийн тодотголоор бол санхүүжих дүнг нь бууруулж ирж болохгүй тийм хуультай. Тэгэхээр бол бид нар ямар нэгэн байдлаар үзэмжээр бууруулж ирэх боломжгүй. Ганцхан зүйлээр бууруулж байж болно. Тэр нь болохоороо худалдан авах ажиллагааг бол 5 сарын 31-ний дотор хийх ёстой байгаад байгаа. Энэ хугацаанд худалдан авах ажиллагаа хийж чадаагүй бол үлдэж байгаа төсвийн жилийн хугацаанд бол энэ худалдан авах ажиллагаа хийх хугацаагүй гэж үзэж хэмнэлтийн хуулийн яг тэр зарчмын дагуу энэ хэмнэлтээр зохион байгуулалт нь орж чадаагүй худалдан авах ажиллагаагаа хугацаандаа зохион байгуулж явж чадаагүй энэ хөрөнгө оруулалтууд л хасагдсан. Бусдаар бол өөр хөрөнгө оруулалтыг бол огт бууруулаагүй тийм байгаа. Тэгээд сайд нар нь нэмж хариулт өгөх нь зөв байхаа.

Эхлээд Сангийн яамны хариулах гэж байна уу эсвэл Идэрбат сайд хариулъя. Яг хөрөнгө оруулалтаас хасагдсан яг ямар ямар төсөл хөтөлбөрүүд хасагдчихав.

Ц.Идэрбат: Тийм энэ хөрөнгө оруулалттай холбоотой юун дээр энэ нөгөө Тендерийн хууль дээр 5 сарын 31 болоогүй гээд. Тэгээд аймгууд дээр тавигдсан олон зүйлүүд. Тэгээд энэ чинь нөгөө багцаараа хуваавал нэг жижиг сажиг тоног төхөөрөмж эд нар гээд 30-аад тэрбум төгрөг хасагдаад энэ төсвийн хэмнэлтийн 230 хэдэн тэрбум төгрөгт энд нь ороод явж байгаа. Урсгал зардлаас бол манайх хасагдаад байх юм бол байхгүй. Угаасаа ер нь бидний хувьд энэ 2026 оны төсөв бол нөгөө урамшуулал юмнуудаа өгөөд л ер нь таарч байгаа шүү дээ. Одоо бид нар сүүнийхийгээ өгч чадаагүй байгаа. Сүүнийхэн бол маш бухимдалтай байгаа. Энэ 2, 3 сарын урамшууллыг нь бид энэ төсвийн тодотголын ар дээр бүгдийг нь өгнө. Сүүнийхээ урамшуулал сүү хөтөлбөрийг цааш нь үргэлжлүүлэхээр болсон гээд урсгал зардал юмнаас танагдаад байх юм байхгүй.

Нэг трактор жижиг сажиг тоног төхөөрөмжүүд гэсэн зүйлүүд хуулийн хугацаандаа хасагдаад ингээд явсан зүйл байгаа гэж хэлье.

М.Мандхай: Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн тодотголтой холбоотой хэмнэлтэд орсон төслүүд гээд энэ мэдээллийг хараад байж байгаа юм аа. Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ХХААЯ-аас холбогдох танагдсан төслүүдийг нь 2027 онд эдгээрээ яах юм бэ гэсэн асуултыг асуух гээд байгаа юм.

Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам дээр харагдаж байгаа нь 14.1 тэрбум төгрөг хэмнэлтэд орсон байгаа юм. Бусад гэдэгт 7.2, их засвар тоног төхөөрөмж 6.9 мэдээж хэрэгтэй байсан зүйлүүдээ л төсөвлөж орж ирсэн байлгүй. Тэгэхээр энэ 2027 оны төсөв дээр энэ хэмнэлтэд орсон төслүүдээ эргүүлж авч орж ирж байна уу ямар төлөвлөгөөтэй байна вэ? Сая сайдын хэлдгээр Идэрбат сайдын хэлдгээр ХХААЯ-ан дээр болохоор 30.7 тэрбум төгрөг хасдаг л даа. Хэмнэлтэд ороод их засвар, тоног төхөөрөмж 26.5, бусад 3.7 ТЭЗҮ, зураг төсөв 0.5 гэж байна л даа.

Тэгэхээр яг энэчээнээс та хариулчихсан учраас яг тодруулаад асуухад ТЭЗҮ зураг төсвийн энэ хасагдаж байгаа дүн нь яг юуны ТЭЗҮ байсан юм бол оо? Юуны зураг төсөв байсан юм бол оо? Энийгээ бас 2027 ондоо үргэлжлүүлэн авч явж байна уу? Энэнд хариулт авъя.

Хоёрдугаар нэг гол асуудал нь болохоор ер нь энэ төсвийн төлөвлөлт тал дээр тэгээд зарцуулалт тал дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, ХХААЯ хэр хамтарч ажиллаж байгаа вэ? Сая Коп гээд том хурал боллоо. Ер нь бол хамтын ажиллагаа маш чухал 2 салбар. Тийм ч учраас яг энэ Байнгын хороонд хоёулаа хамаарагдаж байгаа. Энэ газрын доройтол гэж яригдаж байгаа. Газар тариаланд хэрэглэгдэж байгаа усны хэмжээ, тэгээд цаашлаад энэ уур амьсгалын өөрчлөлтийн цөлжилттэй холбоотой асуудлууд гээд 2 яам хоорондоо нягт бодлогоо уялдуулах ёстой.

Тэгэхээр энэн дээр энэ уялдааг нь хэрхэн хангаж ажиллаж байгаа тал дээр бас тайлбар авъя аа. Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль батлагдсан. 8 сарын 1 гээд нэг журам гарах ёстой. Тэр журам маань бас гарсан эсэх дээр.

Ийм 3 асуултад хариулт авъя.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя. Дараа нь Батбаяр Төрийн нарийн бэлдэж байгаарай.

Ц.Идэрбат: ХХААХҮЯ-ны хувьд бол сая төсвийн энэ тодотгол дээр нөгөө тендерийн хуулийн дагуу хасагдсан зүйлүүд яригдаж байна. Энэ дотор нэг ТЭЗҮ-ийн асуудлууд бас байгаа. Үнэхээр бас яг энэ төсвийг ингээд задлаад ингээд аваад хараад үзэхээр яг тийм шаардлагатай байна уу, үгүй юу гэж эргэлзэхээр олон зүйлүүд байсан. Гэтэл нөгөө талдаа малчид мал мал эмнэлгийнхээ мөнгийг өгч чадаагүй 17 тэрбум төгрөгийн өртэй ч байж байгаа шүү дээ.

Тийм учраас зарим нэг зүйлийг нь танаж хасаж юу руугаа шилжүүлсэн мал эмнэлгийн 17 тэрбумын 10 тэрбумыг нь дарсан гэх мэтийн ийм зохицуулалтууд хийсэн юмнууд байгаа. Нөгөө талдаа бүх юмыг бид нар ингээд улсын төсөв гээд байхаасаа илүүтэйгээр энэ ХАА-н салбар дээр хэрэгжиж байгаа энэ төсөл хөтөлбөрүүдийг гаднын энэ донор байгууллагуудтайгаа яриад саяын энэ ТЭЗҮ энэ олон тоног төхөөрөмж ийм зүйлүүдийг энэ төслийн хөрөнгийг тийш нь зарцуулъя гэдэг дээр ерөнхийдөө бас яаман дээрээ ярилцаад шийдвэрээ гаргаад донор

байгууллагуудтайгаа бас ойлголцоод Сангийн яам дэмжээд ингээд Сангийн яам ХААЯ 2 бол бас төсөв дээр орон зай гаргахын төлөө бас ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ жил хасагдсан тэр тоног төхөөрөмжийн зүйлүүдийг бид нар ХАА-н салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээр бас тодорхой хэмжээнд хэрэгжүүлээд явна гэж ингэж үзэж байгаа. Сангийн яамтайгаа ингэж бас үзэж байгаа. Би энийг зөв зүйтэй зарчим гэж бас харж байгаа. 2027 он дээр энэ 2026 оны орхигдсон төслүүд орж байна уу гэвэл ихэнх нь ороогүй. Айхтар оруулъя ч гэзгүй. Ер нь зүгээр 2027 он дээр бид нар энэ ХАА-н салбар дээр тулгамдаад байгаа энэ арьс ширний үйлдвэрлэл, энэ мал эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт дээрээс нь энэ Био комбинат, энэ вакцинаа өөрсдөө үйлдвэрлэдэг байх энэ том бодлогын юмнууд руугаа бас оруулж байгаа. Тоног төхөөрөмж тодорхой хэмжээгээр яах вэ тусгагдсан. Ингээд явж байгаа төсөл дээр.

Тэгэхээр ингээд юм болгоны араас энийг оруулах юмсан, энийг оруулах юмсан энийг оруулах юмсан гэхээсээ илүүтэйгээр энэ салбарын өмнө тулгамдаад байгаа хаягдаад байгаа энэ арьс ширний үйлдвэрлэлийг баруун талаас нь эхлээд Ховдын эхлүүлчихсэн юмыг дуусгая. Нийслэлийн эхлүүлээд явж байгаа юмыг бас олигтойхон шиг явуулъя. Нөгөө талдаа гадаадаас 30 тэрбумаар авдаг байсан вакцинаа бид өнөөдөр дийлэхээ больж эхэлж байна шүү дээ. Тэгэхээр дотооддоо савладаг энэ био комбинат руугаа анхаарлаа хандуулъя гээд үндсэндээ энэ 2 том салбар луугаа энэ 2027 оны төсвийг чиглүүлж байгаа.

Мэдээж салбар дээр зөндөө асуудлууд байгааг нь саяын миний хэлдэг энэ цахим хоршоо энэ дэлхийн банкны санхүүжилттэй энэ АХБ, Европын сэргээн босголт энэ **астеп** төсөл гээд ингээд олон төслүүд рүү чиглүүлээд энэ төсөв дээр ирэх ачааллаа бас тодорхой хэмжээнд бууруулаад ингээд явж байгаа гэж хэлье.

М.Мандхай: Батбаяр даргын микрофоныг нээе. 2 номер.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр Уянга гишүүний асуултад хариулъя аа. Хөрөнгө оруулалт дээр 2026 оноос шинээр хэрэгжиж эхлэхээр батлагдсан боловч нөгөө төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гэрээ байгуулаагүй 4 төсөл арга хэмжээний 5 багц арга хэмжээ хасагдсан байгаа. Үүн дотор нөгөө Онги-Цагаан бургастай төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг мөндөр манан сарниулах чиглэлд үүрэгжүүлэх явуулын радаар мөн автомат станц суурилуулах ажлууд байгаа. Үлдсэн 2 нь Коп-17-той холбоотой барилга тоног төхөөрөмжийн ажлууд байсан.

Тэгэхээр үүнээс ирэх жил төсөвт орж байгаа нь бол Онги-Цагаан бургастай төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил орж байгаа. Бусад ажлуудад нь бол хасагдаж байгаа. Коп-17 хурал нэгэнт зохион байгуулагдсан учраас энэ тоног төхөөрөмж барилга байгууламжтай холбоотой зардлууд ирэх онд орох шаардлагагүй байгаа.

Хоёрдугаарт энэ жил бэлчээр газрын доройтлыг бууруулах олон улсын жил болж байгаатай холбоотой.

М.Мандхай: Гүйцээж хариулъя.

Ш.Батбаяр: 2 яам маань төсөл төлөвлөгөөнүүдээ хамтран боловсруулах чиглэлээр нэлээн өргөн хүрээтэй хамтарч ажиллаж байгаа.

Гуравдугаар асуулт бол Үнэлгээний хуулийг дагаж гаргах журам маань яамдуудаас нэлээн саналууд авсан. Тэгээд ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар оруулж батлуулахаар ажиллаж байгаа. Манай яамнаас бол Засгийн газар руу саналаа өгчихсөн байгаа. Хэрэг эрхлэх газар руу.

М.Мандхай: Нанзадын Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Өдрийн мэнд хүргэе ээ.

Сая бас тойргоороо ажилласан говийн бүсийнхээ малчидтай хөдөө сумдуудаар ажилласан. Энэ шүлхий малын өвчний асуудал ер нь хүнд байна шүү. Ер нь хаа сайгүй гарсан, нэлээн тархчихсан байдалтай байна. Тэгээд хүйтрэх гэж байгаа. Хүйтэнд чинь улам тэсвэртэй гэж байгаа. Тэгээд мал мах бэлтгэл хийх цаг болж байдаг. Ер нь энэ вакцины төсөв ямар байсан юм, хүрэлцээ хангамж ямар байгаа юм. Энэ тодотгол дээр бас энэ вакцинтай холбоотой төсөв нэмэгдэж хасагдаж байгаа юм байгаа юу гэсэн асуулт асууя. Тэгээд тодруулъя.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя.

Шүлхий бол Монголын МАА-н зовлон болсон нь үнэн шүү. Тэгээд шүлхийний тарилга жилдээ 2 удаа хийгддэг. Тэгээд өнгөрсөн 2025 оны энэ тарилга бол тэгээд хар өвлөөр, дүн өвлөөр идэр 9-ийн хүйтэн тачигнаж байхад тэр үед хийгдсэн вакцин чанаргүй болсон гэж үзэж байгаа, тарилга чанаргүй болсон гэж үзэж байгаа.

Тийм учраас нөгөө шүлхийн О хэвшил маань хонь руугаа бог руугаа орчихсон, маш төвөгтэй байдалтай байгаа. Түүн дээр нь нэмээд сад хэвшил орж ирсэн. Баруун аймгуудаа ямар ч байсан цэгцэлсэн. Зүүн аймгуудаа маш хурдан зохион байгуулалтын арга хэмжээ хийгээд ингээд өнөөдрийн байдлаар шүлхий өвчний гаралт Монгол Улсад байхгүй байгаа гэсэн ийм мэдээтэй албан ёсны мэдээтэй байгаа. Гэхдээ энэ бог дээр бас бай мэр сэр гарч байгаа. Энэ ялангуяа Дундговийн хойд талын тэр Адаацагаас авхуулаад энэ Өвөрхангайн урд талын сумдууд гээд энэ нэг хэдэн сумдууд Төв аймгийн энэ урд талын хэдэн сумдуудаар бог дээр нэлээн халдварууд бас гарсан. Бид энэ О хэвшлийн энэ шүлхийн вакцин 200 гаруй мянган тун вакциныг бог руу тарих энэ ажлыг бас зохион байгуулсан. Яг одоогоор ингээд гараагүй гэсэн ийм мэдээтэй байна. Одоо ингээд намрын тарилга эхэлнэ ээ. Энэ 9 сарын 11 буюу энэ 5 дахь өдөр гэхэд 2.6 сая тунг тэгэхдээ энэ нь О, Сат хэвшлийг хавсаргасан энэ вакцин байгаа.

Тэгэхээр бид нар яг энэ технологийнх нь хугацаа буюу 9 сарын 15-аас 10 сарын 15-ны хооронд 1 сарын хугацаанд энэ Монгол Улсад 6 сая гаран үхрийг бол чанартай тарьж гүйцэтгэхээр бэлтгэл ажлаа хангачихсан явж байна. Энэ 5 дахиас эхлээд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв аймаг, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр гэсэн 5 аймаг нийслэлийн эргэн тойрон гэсэн сумдуудад аймгуудад вакцин хүргэгдэнэ ээ. Ингээд улсын хэмжээнд бол 9 сарын 15 гэж дуусна. Тэгээд эндээс бол бас үр дүн бид хүлээж байгаа. Яагаад гэвэл урин дулаан цагт мал тарган байхад хийлгэе. Тэгэхээр малчдын хувьд бол нөгөө өвөл яг мал ядарч байх үед вакцин тарихаар үхэр хорогддог. Тэгээд үүнээсээ болоод тариулахгүй байх малчин мал эмнэлэг 2-ын хооронд зөрчилдөөн үүсэх, нуух, дарах гээд олон сөрөг үзэгдлүүд

байдаг. Одоо яг намрын энэ сайхан хайлган цагаар малчид дургүйцэхгүйгээр тариулна гэж ингэж бас харж байгаа юм.

Тэгэхээр энэ шүлхий өвчинтэй бид нар хугацаанд нь л тэмцэнэ. Нөгөө талдаа бол энэ шүлхийн өвчний энэ вакцины үнийг дийлэхээ байлаа. О хэвшлийн вакцины үнэ 1500, 1600 байдаг байсан бол одоо энэ О, Сат-1-ийг холиод ирэхээр энэ чинь бараг дабльдаад гараад ирэх гээд байна шүү дээ. Туйлын хүнд байдалтай болоод байгаа юм. Тэгэхээр дотооддоо савлах барих энэ Био комбинатын хөгжил рүү энэ 2027 оны нэгдсэн төсвөөс бас тодорхой хэмжээний мөнгө төгрөг тавьж энэ био аюулгүй байдал тал дээрээ бас энэ мэргэжлийн байгууллагыг нэг байгууллага шиг байгууллага болгохын төлөө л зорьж байгаа. Тэгж байж бид тэр бог дээр гарсан шүлхийний асуудлаа шийдэх юм билээ. Тэрнээс 30 сая.

М.Мандхай: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Энэ жил 2026 оны төсөв дээр вакцинжуулалттай холбоотой хэдий хэмжээний төсөв тавьсан юм? Одоо үлдэгдэл ямар байгаа юм? Татан авалт, нөөц ямар байгаа юм гэдэг дээр тодруулъя.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Үндсэндээ нэг 30-аад орчим тэрбум төгрөг энэ шүлхийн вакцин дээр ер нь тавигддаг. Энэ худалдан авалтуудыг хийхэд бол санхүүгийн хүндрэлүүд гарч байгаа. Яагаад гэвэл ганцхан нэг хэвшлийн биш, 2 хэвшлийн шүлхий болж байгаа учраас дахиад 60, 70 хувиар нэмэгдээд ингээд явж байгаа. Бид энэ 6 сая тун үхрийн О, Сат-1 хэвшлийн энэ вакциныг хийж дууссаны ар дээр бидний нөөцөд бол 450-аад мянган О, Сат-1 хэвшлийн вакцин нөөцөд бид авч үлдэнэ. Дахиад цааш нь төлөвлөж байгаа юм бол яг таны хэлж байгаа хонин дээр гараад байгаа энэ О хэвшилд зориулж нэг гаднын байгууллагууд руу бас дэмжлэг хүсэж байгаа. Үүгээр хэрвээ амжилттай болбол 200 мянган тунг ингээд аваад үлдэнэ. Бид төлөвлөсний дагуу бол 2027 оны намраас өөрсдийн савласан вакциндаа залгачих юмсан гэсэн ийм л зорилготой ажлын хэсэг гаргаад холбогдох байгууллагуудтай нь холбогдоод ингээд ажиллаж байгаа.

М.Мандхай: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя.

Н.Алтаншагай: Гишүүдтэй бас асуудал давхардаж байгаа зүйлүүд байна. Тэгэхдээ нэг 2 зүйлийг тодруулж асууя. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн энэ өдрөөс өдөрт өсөж байгаа. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн зөрөө өмнөх оны мөн үеийнхээс харьцуулахад инфляцынх нь түвшин ямар байгаа вэ? Төсвийн тодотголд стратегийн зарим барааны нөөц хангамжийг тогтворжуулна гэж 150 тэрбум төгрөгийн тусгаж байгаа юм байна. Энэ мөнгөнөөс энэ нөөцийн махандаа яг хангалттай хэрэглэж чадах уу? Нийслэл рүү орж ирэх үү? Хавар 4, 5 сард 36 мянгатай байсан үхрийн мах одоо 30 мянгатай байна. 26 мянган төгрөгийн үнэтэй байсан хонины мах 24, 25 мянган төгрөгийн л үнэтэй байна.

Үнийн зөрүү бараг л арилж чадаагүй. Тэгэхээр энэ их татаас өгөх юм уу, энэ хөнгөлөлттэй зээл олгох юм уу? Энийг эргээд яг бодит үр дүнгээ өгч чадах уу? харьцангуй тогтвортой л байх байх махны үнэ. Он гараад энэ өсөөд эхэлнэ.

Тэгэхээр энийгээ яг барьж чадах юм уу? Энэнээсээ дээшээгээ тавиад туучих юм уу.

Хоёрдугаар асуудал нь энэ Улаанбаатар хот удахгүй утаатайгаа нүүр тулах гэж байна. Байгаль орчны яамныхан. Энэ Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо гээд энэ Байгаль орчны яаманд харьяалалтай байна уу? Бодлогын яг ямар юмнуудыг энэ дээр энэ төсвийн тодотгол дээр болон 2027 оны төсөв дээр тусгах юм бэ? Улаанбаатар хот гэлтгүй энэ төв суурин газрууд чинь бүгд энэ утаатай болчихлоо шүү дээ. Түүхий нүүрсээ түлж байгаа юм. Зөвхөн энэ утаатай тэмцэнэ гэхээр Улаанбаатар хотын утаатай ярилтгүй болсон. 21 аймаг чинь суурин газрууд бүгд утаатай болсон. Улаанбаатараас илүү утаатай болсон. Улаанбаатар хотын энэ нөгөө утаагүй түлшээ энэ дэд бүтцээ энэ бүтээгдэхүүнээ өвлийн нөөцөд бэлэн үү? Хариулт аваад тодруулъя.

М.Мандхай: Хэн хариулах вэ? Сангийн яам 2 номер.

Б.Мөнх-Эрдэнэ: Мөнх-Эрдэнэ Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга. Инфляцын тухайд 2026 оны 7 дугаар сарын байдлаар 13 хувийн өсөлттэй байсан. Сая бид нар ҮСХ-той тооцоолол бас нэгтгэж үзээд 8 дугаар сарын эцсийн инфляц 12.5 хувь буюу 0.5 нэгж хувиар унаж байгаа үзүүлэлттэй байна. 7 сарын эцэст хамгийн өндөр өсөлтийг үзүүлж байсан нь бол ойролцоогоор 4.9 нэгж хувиар мах өссөн байсан. Одоо 8 сарын эцсийн байдлаар сүүлийн нэг сард махны үнэ буурсан байна. Үхрийн мах бол 6-7 хувиар. Хонины мах 6 хувиар сарын хэмжээнд буурсан байна аа. Мөн ногоо төмсний үнэ бол сүүлийн нэг сард бол буурсан байна. Төмсний үнэ 49 хувиар буурсан байна. Тэгээд инфляцын тухайд ийм байна.

Инфляцын тухайд мөн хамгийн их нөлөө үзүүлсэн төмс, махны үнэ бол жил дотроо сар, улирал, улирлын хэлбэлзэлтэй байдаг 4, 5, 6 сард хамгийн их өсдөг.

Тэгэхээр энэ нөөц бүрдүүлэлт нөөцийн махнууд яг тухайн үнэ өсдөг сар улирлууддаа бол саармагжуулах нөлөөтэй байдаг аа.

М.Мандхай: Асуултаа гүйцээж хариулъя.

Стратегийн хүнс үнийг тогтворжуулахад 150 тэрбум төгрөг зарцуулсан. Нийслэлд орж ирэх юм уу энэ мөнгө чинь гэдэг асуулт байсан. Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Энэ стратегийн нөөц бүрдүүлэх энэ асуудал бол нийт утгаараа Монголын ард түмний л хоол хүнстэй байх асуудал шүү дээ. Тэр газар тариалангийн нөөц байна, энэ гурилын нөөц, тэр шатахууны нөөц бол бүхий л газар тариалан эрхэлж байгаа ААН иргэдэд очдог гэдэг утгаараа бол. Яг энэ хүнсний ногоо, нийслэлийн мах 2 бол яг нийслэлийн ард иргэдэд л зориулсан ийм л зүйл. Одоогийн байдлаар бид түрүүнд бас би хэлж байсан. Нийслэл маш сайн тийм төлөвлөгөө гаргасан байна лээ. Энэ өнөөдөр ингээд арван хэдэн жил явж ирсэн энэ хэвшлийг өөрчилъе өө. ААН-үүдийг оруулж ирье гээд маш шинэлэг зүйл оруулж ирсэн. Гэхдээ бидэнд цаг хугацаа богино байгаа учраас уламжлалт аргаараа явъя аа энэ удаадаа. Бидний нөөц бол 15-аас 20 мянган тонн мах бэлтгэнэ. Яг авсан мөнгөндөө мах авсан уу үгүй юу гэдгийг нь л хатуу хяначихъя л гэж байгаа юм. Ингэх юм бол нөгөө 3 сарын 15-аас 6 сарын.

М.Мандхай: Гүйцээж хариулъя. Идэрбат сайд.

Ц.Идэрбат: 6 сарын 15 хүртэлх цаашлаад 7 сарын 1 хүртэлх хугацаанд бас сая хэн танилцуулж байна. Яг махан дээр ингээд тодорхой хэмжээний үнэ дээр ингээд нөлөө үзүүлээд ингээд явна гэж ингэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ 150 тэрбум төгрөгийн энэ гурил мах энэ бүх зүйлүүд бол тэгээд нийслэл дээрээс нь тэгээд Монгол Улсын хүн ардын хоол ундтай холбоотой ийм л асуудал.

Өнөөдрийн бай байдлаар 7, 8 ААН яг далан хэдэн тэрбум төгрөгийн эрхээ арилжааны банкнуудаас авчихсан. Мах бэлтгэл рүүгээ явж байна. Хөдөөд махны үнэ Дэнжийн мянга дээр энэчээ хөдөөгөөс ирж байгаа мах өчигдөр миний авсан мэдээллээр бол хонины мах 17500, 18 мянгатай л байна шүү дээ. Үхрийн мах 20, 21-тэй. Тэр чинь 100-аас дээш хилтэй байна уу үгүй юу гээд ингээд бас янз янз байгаа. Энэ дээр зүгээр би бас нэг зүйлийг хэлэхэд ингээд хавар ингээд.

М.Мандхай: Гүйцээгээд хариулъя. Махны үнэ унасан олон хүчин зүйлүүд байгаа. Гэхдээ энэ нөгөө жишээ нь үнэхээр тугал байхаас нь тэжээгээд хүн цалинжуулаад үнэтэй тэжээл өгөөд тариа будаа тариад ингээд яг зах зээл дээр гаргаж ирсэн тэр нойтон махыг Улаанбаатар хотод махны үнэ тэд болчихлоо гээд ингээд энэ чинь бэлчээрийн үхэр, тэр үхэр 2-ын хооронд чинь шал өөр 2 юм байгаа шүү дээ. Тэгэхээр энийг ингээд харьцуулж ингэж яриад энэнээс болоод бас тодорхой хэмжээнд бас энэ хөдөлсөн гэдгийг бас би зориуд бас хэлье гэж ингэж бас бодож байгаа. И Март дээр тэд байна аа. Үхрийн мах ёстой хаданд гарлаа. Тэр И март дээр байгаа үхрийн мах чинь бэлчээрийн үхэр биш болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр үхрийн махны үнэ тэд боллоо л гээд ингээд яриад байдаг. Энэ 2-ын хооронд чинь зарцуулсан хөрөнгө, зориулалт бүх юм нь шал өөр байгаа шүү дээ. Тэгэхээр ингээд энэ махны үнийн асуудал дээр бас хаана хаанаа л жоохон бодолтой хандахгүй бол болохгүй юм байна даа гэж өнгөрсөн хавраас авсан сургамж.

М.Мандхай: Байгаль орчны яам хариулъя. Улаанбаатар утаатай залгах. 2 номер хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр Алтаншагай гишүүний асуултад хариулъя аа. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо түүний дэргэдэх ажлын алба хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ жилийн хувьд бол БНСУ-ын буцалтгүй тусламжаар 21 аймгийн төвүүдэд агаарын чанарыг шалгах станцыг барьж өнгөрсөн даваа гарагт ашиглалтад оруулсан байгаа. Мөн ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар Нийслэл хотын Багануур дүүргийн нүүрсний уурхайг түшиглэсэн нүүрс перилозын үйлдвэрийн байгуулах хамтарсан хувь төр хувийн хэвшлийн хамтарсан байгууллага хувийн компанийг байгуулах Засгийн газрын төслийг боловсруулан ажиллаж байна.

2027 оны хувьд бол 12 төсөл арга хэмжээнд 4.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөн ажиллаж байгаа. Үүн дотроо мөн бас хувийн хэвшлүүдийг ногоон санг зээл авах боломжийг бүрдүүлж байгаа 600 сая төгрөгийн хөрөнгө оруулалт орж байгаа.

М.Мандхай: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Тодорхой хэдэн асуудал ярьчихъя аа. Стратегийн нөөц дээр улаан буудайн мах, хүнсний ногоо, төмс, хүнсний ногоо гээд. Мэдээж улаан буудайгаар ярих юм бол энэ 100 мянган тонн буюу 1 сая центр ургацын тухай ярьж байгаа. Тэгээд дунджаар нэг га-аас 20 гээд яг бэлэн хурааснаар 20 гээд тооцох юм бол 50 мянган гагийн ургацын асуудал ярьж байгаа. Энэ бол бас манай тариаланчдад том

дэмжлэг болно оо. Яагаад вэ гэхээр намар энэ гурилын үйлдвэрүүд улаан буудай худалдаж авах санхүүгийн асуудалтай байдаг ингээд өгчихдөг. Тэгээд нөгөө мөнгөө авч чадахгүй ингээд л шинэ онтой золгох гээд ингээд явдаг. Энэн дээр их том дэмжлэг болно оо энэ зөв бодлого.

Харин энийг авахдаа бас аль болох жигд хамруулах талын асуудлыг нь ярьсан нь зөв байх. Махан дээр 20 мянган тонн, 20 мянган тонн мах гэдэг бол ойролцоогоор 1 сая 300 мянган толгой хонины махны тухай асуудал яригдаж байгаа. Хонины махаар бодох юм бол. Тэгэхээр энэ бол бас яах вэ гэхээр тийм бага мах бол биш. Мэдээж энэ нөөцийн мах гэдэг байдлаар иргэдэд танигдчихсан.

Тэгэхээр энэ дээр тэр цаасан мах болгочих вий гэдэг асуудал хүмүүсийн дунд нэлээн хардлага явдаг тиймээ. Яг бичилт хийгээд бодитой мах нь байдаггүй. Махаа яг хэрэгцээтэй хүмүүст нь өгөх гэхээр мах нь байдаггүй энэ тэр гээд асуудал яригддаг аа. Тэгэхээр энэ дээр нэлээн анхаарч ажиллах байдлаар Ерөнхий сайд бас ярьж байна лээ.

Тэгэхээр энэ асуудлаа нэлээн анхаарна биз дээ. Төмс хүнсний ногоон дээр ярих юм бол энэ 12 мянган тонн гэдэг чинь гагийн га-аас 200ц 20 тонноор бодоход 600 га-ийн ногооны асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр хаана хаанаас авах вэ гэдэг дээр сайд бас ингээд хариулаад байна. Яг гол бүс нутгуудаас гээд. Тэгээд энэ чинь өөрөө нөгөө маш хэврэг хүнс. Тэгэхээр энэ хадгалалтын горим маш өндөр стандарт шаардсан хадгалалтын горим шаарддаг ийм хүнс. Тэгээд эргээд муудаж барих ангилан ялгахгаас өгсүүлээд асуудал гардаг аа.

Тэгэхээр энэ дээр нэг 2 асуулт байгаа юм. Ямар ямар төрлийн хүнсний ногоо орж байна. Төрлүүдийг нь та нэг хэлчхээч тийм тийм гээд.

Хоёрдугаарт энэ хүнсний ногоон дээр би бас яриад байдаг энэ урамшуулалтай холбоотой тэр хүнсний ногооны урамшуулал гэдэг чинь үр дүнгээ өгөөд явж байсан. Тэгээд тодорхой таримал буюу манжин дээр урамшууллыг нь хасчихсан тэгээд яг ном журмаараа тариад энэ юмандаа хамрагдаад явах улсууд н байнга над руу энэ асуудлыг тавьдаг. Тэгээд ярихаар ингээд зарим нэг хүмүүс ингээд асуудал үүссэн падаан юун дээрээ асуудал гаргасан гээд ярьдаг. Тэгэхээр 1 үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг ингээд нэг хэсэг хүмүүсийн буруутай үйлдлээс болоод ингээд манжин тариалагч нар тэр даяараа хохирмооргүй байна аа. Энэ дээр би нэг тодорхой хариулт авмаар байна.

Дараагийн асуудал нь нөгөө манайхан чинь ингээд л яг бодлого болоод урамшууллуудыг мэдээж тооцоолоод л бүгдийг нь ингээд оруулж ирж байгаа шүү дээ. Нэг багц болгоод л ингээд Улсын төсөв Их Хурлын гишүүд батлаад явуулдаг. Тэгсэн нөгөө сүүний урамшуулал байхгүй болчихсон. Нөгөө 3 сар, 4 сарын сүүний урамшуулал биш 2, 3 сар ч билүү тийм ингээд нөгөө 4 сарын 1-ээр зогсож байгаа учраас 2, 3 сарын сүүний урамшууллаа хүлээгээд нөгөөдүүл авч чаддаггүй. Тэгээд л утас цохидог. Одоо энийгээ та ярьж өгөөч. Энэ юу болчхов оо бид нар бүх юмаа ном журмынх нь дагуу тушаачихсан. Мөнгө нь одоо батлаа биз дээ энийгээ авмаар байна гэдэг асуудал тавьж байгаа юм. Энэ дээр бас тодорхой хариулт авъя. Нэг минутаа авчихъя, нэг минут.

М.Мандхай: Нэг минутаа авчихъя.

Ц.Туваан: Энэ бид нар Малчдын тухай хуулиар сонсгол хийсэн. Тэгээд бичгээ энэ чинь парламентын засаглалтай орон эргээд энэ Байнгын хороон дээрээ шийдээд Засгийн газар руу явуулсан. Тэгээд сая сонсоход энэ 30 тэрбум төгрөгийн гарааны асуудал яригдаж байна. Тэгээд энэ маш их хэмжээний хүнс үйлдвэрлэж байгаа яг энэ хүнсний асуудал бас бус хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн асуудлыг нуруундаа үүрч байгаа малчид руу яг энэ төсвийн тодотгол дээр нэг 30 тэрбумынх нь асуудлыг ядаж энэ дотор шийдээд орж ирж болоогүй юм уу? Энэ чинь цаашаа ярих юм бол бүүр хүүхдийн сургалт нэг удаа үнэгүй эмчлэх энэ тэр гээд маш нарийн бүүр арваад төрлийн давуу байдал олгох заалт яваад байдаг. Тэд нарынх нь бүгдийг нь ярихаа больё гэхэд энэ малчны нийгмийн даатгал дээр сая орон нутгаар явахад маш өндөр хүлээлттэй байна лээ. Тэгэхээр энийг Сангийн яамнаас хариулах уу салбарын сайд хариулах уу? Ийм асуултуудад хариулт авчихъя.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Туваан гишүүний асуултад хариулъя.

Энэ 2026 он бол Монгол Улсын газар тариалангийн салбарын чухал он. 2025 оны гангийн улмаас энэ газар тариалан эрхэлж байгаа ААН-үүд, том жижиг дундгүй л хүнсний ногоо тариалж байгаа иргэд гээд Монгол Улс тарих төмсний үргүй болтлоо л энэ ган энэ ургамлын өвчинд нэрвэгдсэн. Энэ 2026 он дээр Засгийн газар хаврын тариалалт, намрын хураалт түүний ард дээрх энэ борлуулалтын асуудал руу нь л 3 цогц арга хэмжээ авч байгаа л гэж ойлгож болно.

Тариаланчидтай ургацын баланс гарсны ард дээр тариалангийн улаан буудайны өртөг юман дээрээ бид тохирсон, гурилын үйлдвэрүүдтэйгээ бид бас их нааштай бас хэлэлцээрүүдээ бас хийж байгаа гээд ингээд энэ газар тариалангийн салбар дотоодынхоо хүнсний хэрэгцээг ялангуяа стратегийн энэ улаан буудай, гурилынхаа асуудлыг 100 хувь, төмсөө 100 хувь хангах, дээрээс нь хүнсний ногоогоо 70 хувь хангах гээд энд том зорилтыг биелүүлсэн энэ Монголын газар тариаланчдад бид бас талархал илэрхийлэх ёстой. Яагаад гэвэл энэ чинь үнэ нь тодорхойгүй, яах нь тодорхойгүй юм руу зоригтой л орж байна шүү дээ.

Тийм учраас энэ дараагийн буюу энэ өмнө авсан дэмжлэгүүдээсээ дараагийн үе шат буюу энэ эдийн засгийн эргэлтэд оруулахад төр тодорхой хэмжээнд оролцоод төр ямар ашиг олох вэ гэхээр үнийг тодорхой хэмжээнд барих гээд байгаа л ийм интервенц хийх гээд байгаа юм. Энэ нь хаана хаанаа ашигтай байна л гэж ингэж үзэж байгаа юм. 4 төрлийн ногоо авна гэж ингэж үзэж байна. Үүн дээр төмс 10 мянга, шар лууван 2 мянга, сонгино мянга, шар манжин мянга гэж.

Тэгэхээр нөгөө та сая хэллээ нөгөө манжингийн урамшуулал энэ чинь нөгөө нэг зорилтот түвшиндээ хүрэхээр ингээд хасагдаад байгаа. Тэр угаасаа тэгээд хуулиараа тийм юм байна лээ шүү дээ. Хэн нэгэн хүн хасаагүй.

Тэгэхээр нөгөө манжин зорилтот түвшиндээ хүрчихсэн болохоор бид бас энэ манжингийн нөөцийг бүрдүүлээд авъя гээд энэ манжингаа бас урамшуулал байхгүй ч гэсэн төрийн худалдан авалтад оруулаад ингээд явъя гэдгээр ингэж яваа гэж бас хэлье. Тэр хадгалалттай холбоотой асуудал дээр таны хэлж байгаа үнэн. Бид ингээд нэг газар зоорь руу нүхэн зоорь руу аваачаад хийчихвэл энэ олон төмс, ногоо, энэ 30 тэрбум төгрөгийн ногоо хавар гэхэд хүнд хэрэггүй болно. Тэгэхээр нөгөө сүүлийн үеийн технологиор баригдсан зоориудад төмсийг нь тусад нь байцай

лууванг нь тусад нь. Энэ чинь ингээд тусдаа цаг, температуртай, чийгшилтэй ийм газруудад байж байж хэвийн хорогдолтой байна.

Тэгэхээр энэ талаас нь нөгөө сав суулга зоорио бид тодорхой хэмжээнд бэлдээд ингээд явж байгаа гэдгийг бас хэлье.

Дараагийн ээлжид махан дээр цаасан мах болгохгүй ээ. Үнэхээр энэ хавар энэ хавар бас ААН-үүд нийслэлд шал худлаа мэдээлэл өгдөг нь олон юман дээр илэрсэн шүү дээ. Тэгэхээр энэ жил цаасан мах байхгүй. Үнэхээр авсан нэг төгрөгийн зээл болгон эргээд мах болох энэ л хяналтыг тавь гэдэг үүргийг Ерөнхий сайд тавьж байгаа. Энэ ногоон дээр ч ялгаагүй, будаан дээр ч ялгаагүй энэ л зарчим бас адилхан тэгш үйлчлээд явна гэж ингэж хэлье. Тэр олон урамшуулалтай холбоотой асуудал дээр тэгээд өгнө, гөхгүй болоод бас их хүндрэлүүд гарах юм аа.

Тэгээд ерөнхийдөө энэ ХХААЯ.

М.Мандхай: Гүйцээгээд хариулъя.

Ц.Идэрбат: Энэ өгөх ёстой урамшууллуудаа ингээд л тодорхой хэмжээнд өгөөд одоогоор бол яг нэг таны хэлж байгаа энэ сүү дээрээс нь нөгөө мал эмнэлгийн тарилгын хөлс гээд ингээд үндсэндээ нэг 10-аад тэрбум төгрөгийн асуудал л бидний өмнө байгаа. 160 орчим тэрбум төгрөгийн өглөг авлагыг цэгцэлсэн. Одоо нэг 10-аад тэрбум үлдсэн. Энэ төсвийн тодотголын ар тал дээр энэ сүүний урамшууллаа өгнө. Тэр малын тарилга гээд 7 орчим тэрбум төгрөгийн өр авлага байгаа. Энийгээ ингээд нэг цэгцлээд энэ 2027 оны төсөв дээр нэлээн цэвэрхэн баланстай орох юм сан гэж ингэж бас бодож байгаа гэдгийг хэлье.

М.Мандхай: Тодруулъя.

Ц.Туваан: Бид нар бүгдээрээ бас орон нутгаас сонгогдсон гишүүдээ тэгээд энэ махны үнэ дээр хайчинд байгаа. Одоо яг орон нутаг дээр хөөрхий малчид юун дээр мал бүхий иргэд юун дээр амьдарч байна гэхээр нөгөө малаа л зарж амьдарч байгаа. Махны үнэ хөөрхий тэд нарын хувьд харьцангуй боломжийн гэж үзэж байгаа. Тэгэхээр дахиад энэ стратегийн нөөц бүрдүүлэлт дээр анхаараарай. Нөгөө махны үнийг нь унагаагаад бас тэр хүмүүсээ орлогогүй болгочих вий гэдэг асуудал дээр бас анхаараарай. Улаан буудайн үнэ дээр нөгөө стратегийн нөөц бүрдүүлэхэд авах үнийг ярьж байгаа биз дээ. Нөгөө хуучин бол ТЭДС-д авах үнэ гээд тэр бас тариаланчидтайгаа ярьсан л юм байна. 3 дахь нь нэг тодорхой асуудал. Одоо энэ Отгонбаяр гишүүн бид хэдийг байж байхад энэ хадланчид яриад байсан. Энэ хадлангийн тээвэр гэдэг юмыг ингээд хорьчихсон. Дорнодоос ялангуяа. Тэгээд энэ шүлхийн хориотой холбоотой асуудалд Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Малчдын гол орлого олж байгаа мах, махны экспортыг зогсоохгүй гэдгийг хатуу хэлье. Энэ бол нийслэл хэдийгээр 10 гаран мянган тонн мах яалаа гээд энэ нэг их махны үнэд нэг их айхтар тийм доошоо орчихсон үнэ болохгүй болов уу гэж ингэж бодож байна.

Дараагийн асуудал дээр тэр хадлангийн тээвэртэй холбоотой асуудал дээр Өчигдөр өглөө яамны шуурхай дээр Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Алтангэрэлд одоо энэ чинь бид нар 20-нд гарсан шүлхийг нь 26-аас эхлээд бид 200 мянган тун вакцин яг голомтыг нь тойруулаад, хамгаалаад тариад бас нэлээн хэд хоночихлоо. Одоо зарим энэ хөл хорио юмнуудаа зогс оо. Хадлангийн тээвэр

юмнуудаа явуул гэдэг чиглэлийг Мал эмнэлгийн ерөнхий газарт өчигдөр яамны сайдын шуурхай дээр бас өгсөн байгаа. Тэгэхээр энэ 7 хоногоос ингээд энэ хөдөлгөөнүүд хийгдээд явна. Харин ариутгал халдваргүйтгэлүүд хийгдэнэ.

М.Мандхай: Сонгобайн Замира гишүүн асуултаа асууя.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Одоо ингээд жил болгон махны асуудал үүсдэг бэлтгэл ажилд ч гэсэн тэгээд бэлтгэх, үнийн асуудал гээд. Энэ жилдээ тэгээд махны үнийг тогтвортой барих тал дээр ямар арга хэмжээ авч байна ХААЯ-аас бас асуумаар байна.

Хоёрдугаарт ер нь дайн дажин дэлхий даяар асуудал ихтэй байна. Тийм учраас ер нь манай Монгол оронд нөөцийн мах өргөн хэрэглээний улсын нөөц гэж юм байдаггүй бүрдүүлдэггүй. 2 дугаарт энийг асуумаар байна.

Гуравдугаарт ер нь цалин, тэтгэвэр, тэтгэмж гэж нэмэгдэхгүй. Тэгсэн мөртөө бензиний шатахууны үнэ, цахилгаан, халаалтын үнэ, өргөн хэрэглээний бараа, мах нь байнга өсөөд байдаг. Эдийн засаг, хөгжлийн яамнаас энийг асуумаар байна. Ер нь харьцуулж ер нь хийж байгаа судалгаа гэж юм байна уу? Ер нь энэ ард түмний карма энийг дааж чадахаар хэмжээнд байна уу үгүй юу гэдэг дээр яг тодорхой судалгаа байвал тэрийг сонсмоор байна. Ийм 3 асуулт.

М.Мандхай: Маш чухал асуулт асууж байна.

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ хариулъя. 2 номер. Мөн энэ бодлогын асуудал асууж байгаа учраас бас дараа нь ХААЯ бэлдэж байгаарай. 2 номерын микрофоныг өгье.

Б.Мөнх-Эрдэнэ: Бид нар тооцоо судалгааны хувьд бусад судалгааны байгууллагатай хамтраад хийж байгаа. Тэгээд ер нь эдийн засгийн судалгаа дүгнэлтийн хувьд бид юу гэж дүгнэж байна вэ гэхээр одоогийн энэ 13 хувь, 12.5 хувь болж байгаа инфляцын 60-аас 70 хувь нь нийлүүлэлтийн гаралтай инфляцаас болоод байна аа.

Нийлүүлэлтийн гаралтай инфляц бол төр заримдаа зохицуулдаг цөөн тооны хүнсний ногоо, мах шатахуун гэсэн зүйлээс шалтгаалаад байна. Харин эрэлтийн гаралтай инфляц бага байна. Ердөө 30-аас 40 хувь нь байна аа. Эдийн засгийн идэвхжил талаа аваад үзвэл бид нар уул уурхай, уул уурхайн тээврийн салбар сайн байна. Дотоод талдаа худалдаа, үйлчилгээ, уул уурхайгаас бусад салбаруудын идэвхжил муу байна. Тэгээд судалгааны хувьд потенциал үйлдвэрлэлээсээ манай улсын эдийн засаг давж байна уу, буурч байна уу гэдэг үзүүлэлтээр 2025 оны төгсгөлд яг 0 буюу яг потенциал үйлдвэрлэлийн түвшиндээ байсан. Одоо 2026 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн экспорт маань сайн байгаа учраас 2.9 хувиар өндөр байгаа. Гэхдээ үүнээсээ бид уул уурхайн салбараа хасаад үзвэл бусад салбар маань яг потенциал үйлдвэрлэлийнхээ түвшинд буюу 0.5 орчим хувьтай байгаа. Цаашдаа энэ таны хэлсэн гадаад нөхцөл байдал тодорхойгүй. Бид уул уурхайн бусад салбар болох шатахуун эрчим хүч гээд олон эдийн засгийн салбар маань гадаад орчноос хамааралтай учраас гадаад эрсдэлүүд байгаа.

Тийм учраас судалгааны түвшинд одоогийн энэ төсвийн тодотгол ирэх жилийн төсвүүд бол энэ нийлүүлэлтийн гаралтай цөөн хэдэн барааныхаа инфляцыг нь тогтворжуулна гэж үзэж байгаа. Тийм учраас ирэх жил бол инфляц зорилтот 8

хувь орчимдоо байна. Гэхдээ энэ дотроо түрүүн миний хэлсэн нөхцөл байдал эсрэгээрээ буюу нийлүүлэлтийн гаралтай инфляц маань ерөөсөө нэг 30, 40 хувийг нь эзлэх болов уу. Гол нь бол яах вэ нэг 40, 60 орчим хувийг нь эрэлтийн гаралтай инфляцыг өдөөх нь өдөөнө. Гэхдээ эрэлтийн гаралтай инфляц нэмэгдлээ гээд нөгөө талдаа бид экспортоо энэ жилийнх шигээ сайн байлгаад валютын ханшаа тогтвортой байлгаж чадвал 2 дугаарт нь нийлүүлэлтийн гаралтай энэ цөөн хэдэн барааныхаа инфляцыг өсгөхгүй байж чадах юм бол ирэх жилийн инфляцын эрсдэл бол өндөр биш ээ. Бага зорилтот түвшиндээ очно оо л гэж дүгнэж байгаа.

М.Мандхай: ХААЯ хариулъя. Идэрбат сайдын микрофон.

Ц.Идэрбат: Замира гишүүний асуултад хариулъя.

Тухайлан махны үнийн асуудал дээр ярьж байна. Тэгэхээр махны үнийг инфляцад бас нэлээдгүй хувийг эзэлж байгаа учраас ялангуяа нийлүүлэлтийн чанартай инфляц бас өсдөг. Энэ хаврын улирал буюу 3 сарын 15-аас 6 сарын 15 хүртэл энэ зорилтот бүлэг рүү хандсан нөөц. Нийслэлийн нөөцийн махны асуудал дээр энэ төсвийн тодотгол дээр 10 орчим тэрбум төгрөг хүүгийн татаас нь тавигдсан байгаа. Одоогоор бол 8 ААН энэ нөөц бүрдүүлэх ажилдаа орчихсон ингээд ажиллаж байна.

Тэгэхээр энэ хавар бол бас гол нь бид нар нэг ч одоо зээлээр гарч байгаа мөнгө болгоныг л мах болгох гэж байна уу үгүй юу гэдэг дээр л хяналтаа тавиад ингээд явбал бас тодорхой үр дүн гарна гэж ингэж бас тооцож байгаа. Яг тэрнийхээ дагуу бэлтгэл бэлэн байдлаа нийслэл бол бас хангаад ингээд ажиллаж байгаа гэж хэлье.

М.Мандхай: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Сая Эдийн засаг, хөгжлийн яамнаас яг одоогийн энэ үнийн өсөлт бүх юмны үнэ өсөж байна тиймээ. Тэрийг ер нь ард түмний карма дааж чадах уу? Ямар хэмжээнд яваад байна гэдгийг асуусан. Одоогийн шатахууны үнийн өсөлт, өргөн хэрэглээний бараа, мах, цахилгаан, дулаан ард түмний шууд нуруун дээр бууж байгаа шүү дээ. Энгийг л яриад байна би. Тэгэхээр одоо ард түмний хэрэглэх карманд орох мөнгөний юу нь байхгүй, тоо өсгөхгүй. Зах зээлийн бүх юм нь өсөөд яваад байна.

Тэгээд ард түмэн энэ тал дээр ямар байдалтай байгаа. Яг тодорхой бодитой хийсэн судалгаа байна уу гэдгийг асуусан. ХААЯ-аас махны нөөц бүрдүүлнэ гээд явдаг улсын нөөц. Тэгэхдээ яг өргөн хэрэглээний барааны нөөц гэж байдаг уу, улсын нөөц гэж. Энгийг бүрдүүлдэг үү ямар нэг дайн дажин боллоо гэхэд манай Монгол Улс өөрсдийгөө.

М.Мандхай: Нэг минут өгье.

М.Мандхай: Ямар нэг хил хаагдлаа гэж бодъё. Тэгэхээр манай улс ард түмэн хэр хугацаагаар өлсөхгүйгээр өөрсдийг нь өөрсдөө аваад явах Монгол оронд өөрсдөө өөрсдийгөө тэжээж явах ард түмний боломж нөөц гэж юм байдаг уу. Тэрийг л яриад байна л даа. Өргөн хэрэглээний бараа, мах улсын нөөц гээд.

М.Мандхай: Хариултыг Идэрбат сайд, дараа нь Эдийн засгийн яам.

Ц.Идэрбат: Замира гишүүний асуултад хариулъя.

Бид бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний нөөц гэж байхгүй. Гэхдээ стратегийн нөөц болох энэ гурил, мах, хүнсний ногоогоо дотоодоосоо 100 хувь хангах ийм л зорилттой тэрнийхээ ч хүрээнд гурилын жилийн хэрэгцээний 3-ны 1-ийг хариуцаж дааж чадах ийм 100 мянган тонн будаа тэгээд мах бол манай өөрийн мал сүрэг. Дээрээс нь бид төмсний ногоогоо 100 хувь хангаж байна, төмс хүнсний ногоогоо хангаж байна. Энэ л нөөц бүрдүүлэлт. Тэрнээс өөр янз янзын бараа бүтээгдэхүүн энд тэнд нөөцөлж байгаа юм байхгүй. Зүгээр яах вэ гамшиг ослын үед УОК дээр тодорхой нөөцүүд байдаг. Энэ бол бас улсын нууцтай холбоотой асуудал гэж ингэж хэлье.

М.Мандхай: Эдийн засаг, хөгжлийн яам 2 номер хариулъя.

Б.Мөнх-Эрдэнэ: Гишүүний асуултад нэмж хариулъя аа.

Айл өрхийн хувьд өрхийн орлого 2026 оны эхний хагас жилд нэрлэсэн дүнгээр 5.8 хувийн өсөлттэй байсан. Гэхдээ инфляц өндөр буюу 13 хүрсэн учраас өрхийн орлого 2022 оноос хойш анх удаагаа хасах буюу өнгөрсөн жилээсээ 4.9 хувиар унасан үзүүлэлттэй гарсан байгаа. Тэгэхээр энд нөлөөлж байгаа хүчин зүйл бол түрүүн хэлсэн нийлүүлэлтийн гаралтай цөөн тооны инфляцаас шалтгаалж байгаа. Тэгэхээр төсвийн бодлогоороо бол энэ тодорхой тооны бараанууд дээр татаасуудыг тавьснаараа нийлүүлэлтийн гаралтай инфляцынхаа эрсдэлийг бол сайн бууруулж чадна гэж үзэж байгаа. Нөгөө талдаа бид нар Эдийн засгийн яамны хувьд бол экспортыг нэмэгдүүлснээрээ валютын ханшийг.

М.Мандхай: Пүрэвийн. Батчимэг гишүүн асуултаа асууя.

П.Батчимэг: Төсвийн тодотгол жам ёсоороо өнөөдөр ингээд л шат шатанд хэлэлцэгдээд явж байна. Монголын төр, үе үеийн Засгийн газар, үе үеийн энэ Ерөнхий сайдууд үнэхээр нүүр нь шир болж сүүлдээ бүр улам муужирч муудсаар байгаад өнөөдөр попын хаан болсон ийм Ерөнхий сайдтай 160 гаруй хоногийг бид харлаа. Ер нь төсвийн тодотгол хийнэ гэдэг төлөвлөгөөтэй, байгаа олсон, ухаалаг, ийм төлөвлөлттэй, төсвийн зарлагыг бууруулсан, энэ чиглэлээр төсвийн тодотгол хийгдэх ёстой гэж ойлгож байгаа. Эсрэгээрээ өнөөдөр оруулж ирж өргөн барьж байгаа энэ төсвийн тодотгол бол төсвийн зарлагыг нэмсэн ийм зальжин тодотгол орж ирлээ гэдэг дээр АН-ын гишүүд сөрөг хүчин нь үнэхээр шүүмжлэлтэй хандаж маш сэтгэл дундуур байгаа. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны үйл ажиллагааны чиглэлээр ХХАА, Байгаль орчны сайдууд энд орж ирсэн байгаа. Энэ стратегийн зарим барааны нөөц хангамжийг тогтворжуулах дээр 150 тэрбумыг тавьсан байгаа юм. Энэ төсөвлөсөн энэ 150 тэрбум өнөөдөр хүнсний хангамж тэр дундаа махны нөөц, энийг нэмэгдүүлэх, тогтворжуулах тал дээр яг байгаа болсон энэ төлөвлөлт болж чадах уу гэж сайдаас асууя. Бас энэ өнөөдөр Монгол хүн Монгол иргэн бүр амьд явах тэр дундаа эрүүл хүнс хэрэглэх эрхтэй.

Өнөөдөр Монголчуудын өнөөдөр хэрэглэж байгаа хүнс бол өнөөдөр хор болсон хүнсний хангамжийг нэмэгдүүлж чадахгүй байгаа. Хүнсний дутагдалтай байгаа. Өнөөдөр хүнсний ногоогоо бүрэн Монголын газар шороонд ургасан хүнсээр хүнсний ногоогоор хангагдахгүй байгаа. Малын мах нь вакцинтай тийм махаар өнөөдөр идэж ууж амьдарч байгаа. Махны үнээ дийлэхээ больсон. Энэ олон үйлдвэрүүд махны дотоодын үйлдвэрүүдэд энэ хөнгөлөлттэй зээлийг олгоно гэсэн байна. Өнөөдөр Монгол Улсад хэчнээн дотоодын махны үйлдвэр байгаа юм. Яг

тогтвортой ажиллаж чадаж байгаа юм уу. Энэ хөнгөлөлттэй зээлийн дээд хязгаар нь хэд юм, доод хэмжээ нь хэд юм бэ гэдгийг би бас асуухыг хүсэж байна. Тэгээд энэ агуулахын үлдэгдэл, агуулахын үлдэгдлийг өнөөдөр тооцож яаж тооцох гээд байгаа юм. Ямар аргачлал байдаг юм. Энэ борлуулалтыг цахимжуулах ажлыг хийнэ гэж байгаа юм. Яаж цахимжуулах гэж байгаа юм. Орчин үеийн ийм цахимжуулалт, борлуулалтын цахимжуулдаг тэр аргыг үнэхээр нэвтрүүлж чадах юм уу? Ийм нэг аахар шаахар юмаар аргацаасан ийм заалтууд оруулаад ирж байгаа байхгүй юу. Энэнийхээ оронд өөр бодитой ажил хий л дээ. Махны үйлдвэрүүдээ нэм л дээ.

Хүнсний бүтээгдэхүүн энэ хүнсний ногооны энэ газар тариаланч хувиараа хүнсний ногоо тарьж байгаа хүмүүс өнөөдөр зоорь байхгүй, хадгалах ногоогоо хадгалж чадахгүй муутгаад ингээд сууж байгаа шүү дээ энэ хот орчим нийслэл орчимд.

Тэгэхээр энэ хүнсний хангамжийг үнэхээр энэ хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх гэж байгаа бол энэ зоорь агуулахыг бодитойгоор нь олшруулж энийг нэмэгдүүлэх ёстой гэж бодож байгаа.

Өнөөдөр АН-ынхан ингээд энэ төсвийн тодотгол дээр эсэргүүцээд байна, дэмжихгүй байна гэж ингэж яриад байгаа юм. Эсрэгээрээ бид нар дэмжиж байна. Цалин тэтгэвэр нэмэхийг, бүр сайн нэмэхийг өчигдөр Ерөнхий сайд хэлсэн. Бүр ихээр нэмнэ гээд байна лээ маш сайн байна. Аль хэдийн энд нэмчих ёстой байсан.

М.Мандхай: Нэг минут өгье.

П.Батчимэг: Ахмадуудын цалин тэтгэврийг нэмэх хугацаа зөндөө байсан. 1.5 сая болгоод өгөөч гэж өнөөдөр хоолойгоо сөөтөл хашхираад талбай дээр суугаад өнжиж байгаа, нэмж чадаагүй. 2 сая төгрөг хүртэл болгох боломж байсан. Энэ олон цавчаа энэ олон үргүй зардлууд, энэ олон тансаглалаа энэ өндөр шилэн байшинд амьдраад ажиллаад байгаа тэрийгээ хасах хэрэгтэй шүү дээ. Болих хэрэгтэй шүү дээ. Энэ олон сайд дарга нарыгаа дагаж давхидаг тэр хөдөө орон нутаг, дотоодын томилолт, гадаадын томилолтуудаа болих хэрэгтэй шүү дээ. Ерөнхий сайд явна, Их Хурлын дарга явна. Бүгдийг нь ерөөсөө дагаад л ерөөсөө хэчнээн олон машин хэчнээн том онгоцоор ерөөсөө хөлөглөөд л алга болдог. Бизнес классын суудалд ичихгүй бүгдээрээ суугаад явчихдаг шүү дээ. Ард түмэн харахгүй байгаа шүү дээ та нарыг. Тэгэхээр энэ тансаглалаа больж энэ цалин, тэтгэвэр, тэтгэмж энэ багш эмч нарын цалинг ханатал нь нэмэх ёстой.

Засгийн газар өнөөдөр энийг зоригтой хийж чадахгүй байгаа учраас шүүмжлэлд өртөөд байгаа.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Батчимэг гишүүний асуултад хариулъя.

Би түрүүнд хэлсэн 2026 он бол энэ газар тариалангийн салбарт туйлын чухал он. 2025 оны ган бол том жижиг гэлгүй иргэн ААН гэхгүйгээр л нэрвэсэн. Үүний ч хор уршиг ингээд төмсний үнэ 7 сард маш өндөр болж байгаа. Инфляцад нөлөөлж байгаа гэх мэт сөрөг эффектүүд нь одоо ч хүртэл үргэлжилсээр ингээд явж байгаа. Харин 2026 онд энэ Засгийн газар хавар, намрын тариа тарихаас авхуулаад, хураахаас авхуулаад эцэст нь борлуулалт гэдэг нэг ийм том зүйл рүү бас орж ирж

байгаа. Энэ дээр манай газар тариалан эрхлэгчдэд туйлын баяртай байгаа гэдгийг бас би хэлэхийг хүсэж байгаа.

Би таны асуултуудыг 2 ангилж ярья.

Нэгдүгээрт хийж байгаа арга хэмжээнүүд байгаа онож байна уу үгүй юу гэдэг дээр.

Нэгдүгээрт бол энэ газар тариалангийн салбарын энэ 2026 оны энэ том чухал сэргэлтийг бид бас энэ газар тариалангийн салбарын цаашдын хөгжлийн үндэс болгож авч явахын тулд төр стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайг 100 мянган тонноор ингэж нөөцөлж байгаа нь Монгол Улсын гурилын хэрэгцээний 3/1, дараагийн 3/1-ийг нь бол гурилын үйлдвэрүүд өөрсдийнхөө мөнгөөр авна. Үлдэж байгаа 3/1-ээ хэн авах вэ гэхээр арилжааны банкны хөнгөлөлттэй зээлээр авна. Ингэснээрээ бол дотооддоо бид улаан буудайгаараа гурилынхаа үйлдвэрлэлийг хангалтыг 100 хувь хийгээд явна гэдэг дээр тогтчихсон ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ бас би тодорхой үр дүн гаргана гэж ингэж бодож байгаа. Улаан буудай байхгүйгээс болоод гаднаас оруулж ирдэг. Гурил байхгүйгээс болоод гаднаас оруулж ирдгээс болоод энэ салбар өөрөө туйлын хүнд байдалд орсон юм билээ. Тэгэхээр энийг сэргэлтийн он гэж зориуд хэлэхийг хүсэж байгаа юм. Хүнсний ногооны асуудал дээр бол таны саяын яг хэлж байгаа тэр эрүүл аюулгүй эрүүл хүнсээр бид ард иргэдээ хангах ёстой. Тэгэхийн тулд бид дотооддоо үйлдвэрлэдэг байх ёстой. Тэгэхийн тулд одоо ингээд үйлдвэрлээд гарч ирж байгаа энэ бараа бүтээгдэхүүнүүдийг нь бид яг стандартын шаардлага хангасан зоорь юмнуудад хадгалаад арай сүүлийн үеийн, технологи юмаар эргүүлээд борлуулалтад оруулдаг ийм байх.

Гуравдугаарт тэр шатахууны нөөцийн асуудал туйлын чухал байгаа. Нөхцөл байдал хаашаа ч эргэж магадгүй байгаа учраас бид шатахуунтай байхгүй боо намраа хурааж чадахгүй бол магадгүй хавраа эхлүүлж чадахгүй байж магадгүй. Эрсдэлтэй байгаа учраас тодорхой хэмжээнд нөөц бүрдүүлээд ингээд явж байна гэж ингэж хэлье.

Махны хувьд бол мөн ялгаагүй инфляцад гол нөлөө үзүүлээд байгаа энэ бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг. Энэ тэгэхдээ тийм сайн арга биш. Гэхдээ уламжлалт аргаараа явъя. Ирэх оноос нийслэл өөрөө шал өөр маягаар, энэ арилжааны банкнууд, энэ хувийн ААН-үүд бүгд энэ махны зах зээл дээрээ нэгтгэж томоороо орьёо, тусгай зориулалттай ийм ААН-үүдтэй хамтарч ажиллая гээд маш том зүйл тавьчихсан байгаа. Тэгэхдээ цаг хугацааны хувьд арай бас амжихгүй байгаа учраас бид уламжлалтаараа явж байгаа. Нэг дэвшил байгаа нь таны хэлж байгаа цахимжуулах гэж гэж ингэж яриад байгаа. Тэгэхээр энийг нөгөө Санхүүгийн үндэсний төвийн улсын төсөвт үйлдвэрийн газар үнэхээр иргэн Бат мах авна гэж зээл аваад, мах авч уу машин авчхаж уу гэдгийг.

М.Мандхай: Гүйцээж хариулъя.

Ц.Идэрбат: Гүйлгээгээр нь хянана гэж байгаа юм. Тэгэхээр энэ зөвхөн махан дээр ч биш, энэ төмс дээр, хүнсний ногоон дээр, улаан буудай дээр ил тод байх, цахим байх. Энэ яг гүйлгээ зөв хийгдсэн үү үгүй юу гэдэг дээр хяналтаа ингээд тавина. Энэ бол урьд өмнө нь хийгдэж байгаагүй ийм систем. Энийг бүүр Улсын төсөвт үйлдвэрийн газар хянана гэж ингэж үзэж байна. Ирээдүйд таны асуултуудад

хариулъя гэж ингэж бодож байгаа. Тэр зээлийн дээд доод хязгаар гэж одоохондоо тавиагүй ээ. Яг үнэндээ бол энэ махны зах зээл рүү орж энэ бизнес эрхлэх ААН-үүд бас тийм ч элбэг дэлбэг биш байдаг юм байна. Энэ өөрөө маш их мөнгө эргэлддэг нэлээн бас нэг чадалтай, хүн хүчтэй эдийн засгийн хувьд бол бас жоохон хөл дээрээ тогтчихсон ийм ААН-үүд ордог. Нөгөө талдаа бас маш их эрсдэлтэй ийм бизнес учраас нэлээн зорьсон зүтгэсэн ийм хүмүүс ордог учраас энэ дээр ингээд янз янзын хаалт тээг бид тавиагүй, бүгд нээлттэй. Гэхдээ эд нар арилжааны банкаараа тохироод л барьцаагаа тавьдгаараа тавиад л ингээд л нөгөө зээлийн зарчим үйлчлээд л ингээд л явж байгаа.

М.Мандхай: Ахиад гүйцээгээд хариулъя.

Хоёр дахь багц ирээдүйд гэж байна. Тэгэхээр ирээдүйд яг таны хэлж байгаа зоорины асуудал туйлын чухал аа. Энэ Атрын 4 аяны хүрээнд өнгөрсөн 2025 он онд үндсэндээ 14 мянган тонн зоорь орсон байна. Зоорьгүйгээс шалтгаалаад ингээд намар авсан ургацаа аваачаад хямдхан өгчихдөг эд нар ийм хүндрэлүүд байна. Зарим нөхдүүд нь аваад бөөндөж хямдхан аваад яг үнэтэй үнэ өсөх үед нь гаргадаг эд нар гээд нэг ийм л үйлдлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ манай ХААЯ-ан дээр хэрэгжиж байгаа энэ азийн хөгжлийн энэ зарим зээлүүдийг бид нар зоорь руу чиглүүлж өгч байгаа юм. Сая ингээд тариалангийн бүс нутагт явахад бидэнд хөнгөлөлттэй зээлээ ахиухан өгчихвөл бид зоорь барьчихъя гэж байгаа хүмүүс маш их байгаа. Тэгэхээр энэ хүмүүсээ 1 дүгээрт дэмжинэ.

Хоёрдугаарт ер нь Монгол Улсын газар тариалангийн салбарын цаашдын хөгжил бид экспортын чиг баримжаатай байх юм билээ.

Нэгдүгээрт дотоодынхоо хэрэгцээг хангачихдаг, 2 дугаарт энэ 1.1 сая га талбай энэ тариалангийн талбай дээр бид хэрэгцээтэй өөрийнхөө хэрэгцээгээ хангаад бусад талбайд нь экспортын чиг баримжаатай юм хийх ёстой. Үүн дээр яам анхаарах.

М.Мандхай: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: ХХАА-н сайдын хариултыг сонслоо. Яг энэ стратегийн зарим барааны нөөц хангамжийг тогтворжуулахад төсөвлөсөн 150 тэрбум төгрөгийн зарцуулалтыг өнөөдөр яам ерөөсөө тодорхой юунд хуваачихсан байх ёстой л доо. Яг юу юунд зарцуулах вэ гэдэг тэр задаргаа тэрийг би хариултаа авч чадсангүй. Ер нь бол Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баримтлан Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа энэ тодотгол нь төсвийн зарлагыг бууруулаагүй, харин ч эсрэгээрээ нэмэгдүүлж төсвийн нөгөө бүтцийг өөрчлөх ийм зарчмаар оруулж ирж байгаа юм. Урьд ашиглагдаагүй байсан төсвийг одоо ингэж ингэж шилжүүлж байгаа гэдгээр ингээд.

М.Мандхай: Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Энэ 150 тэрбум төгрөг дээрээс нь манай ХАА-н корпорац тэр улаан буудайн нөөц худалдаж авахад зориулаад бас нэг 50-аад тэрбум төгрөг байгаа. Үндсэндээ ингээд 2 зуугаад тэрбум төгрөг болж байгаа. Тэгэхээр энэ 2 зуугаад тэрбум төгрөг бол зөвхөн энэ 2027 онд, 2026 онд зарцуулагдаад байхгүй болчих мөнгө биш. Энэ бол эргээд будаа болно, эргээд бензин болно, эргээд ногоо болно, эргээд мах болно. Эргээд энэ ХАА-н корпорацын дансанд ороод ирнэ. Тэр явуулдаг худалдан авах тэр дүрэм журам бол ХАА-н биржээрээ дамжуулаад ил тод

байх энэ журмынхаа дагуу л ингээд явна. Задаргааны хувьд бол бид улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэлт дээр 80.7 тэрбум төгрөг, энэ дээр сая нөгөө саяын миний хэлдэг 50 хэдэн тэрбум төгрөг маань нэмэгдээд үндсэндээ 100 гаруй мянган тонн улаан буудай авна гэж ингэж тооцож болно. Төмс, хүнсний ногоон дээр бол 30.7 тэрбум төгрөг. Эндээс нэг 12-оос 13, 14 мянган тонн төмс авна. Төмс, сонгино, лууван, манжин гэсэн 4 төрлийн ногоо авна. Ургац хураалтад шаардлагатай шатахууны хангамж буюу 5 мянган тонн.

М.Мандхай: Гүйцээж хариулах уу? Ургац хураалтад шаардлагатай шатахууны хангамжид 24.6 тэрбум үүгээрээ бид 5 сая литр бензин түлш авна гэсэн ийм зорилттой байгаа. Гурилын үйлдвэрлэлд хүүгийн дэмжлэг бол 3.9 тэрбум төгрөг байгаа. Нийслэлийн хүн амын хэрэгцээний нөөцийн мах бүрдүүлэхэд зээлийн хүүгийн дэмжлэг дээр бид 10.1 тэрбум гээд ингээд үндсэндээ 150 тэрбум ХАА-н корпорацын дансанд байгаатайгаа нийлээд 200 орчим тэрбум төгрөг тэгээд энэ бол ингээд энэ намар энэ эд материал болно, ирэх хавар, намар гэхэд мөнгө болно. Эргээд дахиад будаа, гурил ийм зүйлүүд болно. Тэгэхээр энэ бол нөгөө тариалан эрхлэгчдийн олон жил ярьж байгаа захиалгат тариалан гэдэг юм руугаа нөгөө талдаа энэ Солонгос, Хятад, Японд хэрэгжээд байгаа тодорхой хэмжээнд төр төрийн зохицуулалттайгаар худалдаж аваад үнийг тогтвортой хэмжээнд барьдаг тэр Солонгосын крак зах эд нар гээд байгаа шүү дээ. Яг тэрний л суурийг нь нэг зөв тавьчих юмсан л гэж бодож байна.

М.Мандхай: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Бид нар ч өчигдөр ингээд ээлжит бус хурлаар төсвийнхөө 2026 оныхоо Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах гээд явж байна. Ер нь уг нь нөгөө АН-ын бүлгээс энэ төсвийн тодотголоо зардлаа сайн хяна л гэсэн юм. Харамсалтай нь эсрэгээр нь зардлаа нэмээд ороод ирүүлчихсэн. Яг бодитой хэмнэгдэж байгаа зардал бол энэ сайд нарын багцаас нэг 433 тэрбум төгрөг байна. Гэхдээ ингээд сая энэ Байнгын хорооны хурал дээр сонсож байхад энэ 433 тэрбум төгрөгийн чинь үндсэндээ 4/1 нь манай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны харьяа 2 яамнаас л хасчихсан юм байна шүү дээ. ХХААХҮЯ, Байгаль орчны яамнаас үндсэндээ 120-оод тэрбумыг ингээд хассан л юм байгаа юм байна. Бид нар уг нь хамгийн чухал яамнууд дээрээ ялангуяа энэ дэлхийн эдийн засаг хүнд, энэ хүнс, бусад зүйл хомсдож байгаа үед энэ хүнсний нөөц 150 тэрбум гээд л яриад л байна. 2 жилийнхээ хүнсний нөөцөөр сая хурал хийчихсэн улсууд шүү дээ бид нар чинь. 300 тэрбумаар Копын хурал сая хийчихсэн биз дээ. Одоо тэгсэн чинь инээдтэй жилийнхээ хүнсний стратегийн нөөцийг 150 тэрбумаар гээд үндсэндээ 150 тэрбум төгрөгийгөө дотор нь яаж хэчнээн тэрбумаар нь гурил төмс шатахуун юу ийм л юм яриад сууж байна шүү дээ.

Тэгэхээр энэ төсвийн хэмнэлт гэдгийг бол бид нар бас бодууштай зүйл байгаа юм гэдгийг. Тэгээд Батбаяр даргаас энэ Байгаль орчны сайд байхгүй байгаа юм уу тэ? Сандаг-Очир сайд хаачсан юм? Орон нутагт явж байгаа. 3 асуулт энэ дээр байна.

Нэгдүгээрт нь та түрүүнд энэ хүмүүсийн асуултад хариулж байхдаа. Онги-Цагаан бургастай төсөл нөгөө байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь Төсвийн хэмнэлтийн тухай хуульд орчихсон юм уу? Ямар шалтгаанаар орчихсон юм? Өнгөрсөн жил уг нь энийг чинь явуулах гээд ТЭЗҮ-ийг нь тавих гээд би Төсвийн байнгын хороо, чуулган дээр ярьж байж 9.5 тэрбум төгрөг тавиулж өгсөн шүү дээ.

Тэр байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь хэдий зардалтай ямар шалтгаанаар яахгүй он дамнаад явж байгаа юм бэ гэдэг асуулт.

Хоёрдугаарт нь Хэрлэн тонн усны төсөл байгаа юм. ТЭЗҮ нь Мон хидро констракшн хийгээд үндсэндээ дуусгаад хүлээлгээд өгч байх шиг байна. Сая нөгөө алдартай 300 тэрбум төгрөгөөр арваад хоног үргэлжилсэн хурал хийгээд үр дүнд нь үнэхээрийн үнэн бол 5 их наядын сураг гараад байгаа юм. Эндээс Хэрлэн тоонот төслөө санхүүжүүлэх санал оруулсан уу? Энэ дээр ямар төслүүд говь руу татах усны төслийг ямар санхүүгээр, эх үүсвэрээр санхүүжүүлэх гэж байгаа вэ гэдэг асуудал байна.

Гурав дахь асуудал нь энэ Говьсүмбэр аймагтай холбоотой би өчигдөр танай сайд руу албан бичиг явуулсан байгаа юм. Энэ сумдуудынх нь эрх мэдэл хүрдэггүй юм уу, аймгууд нь ажлаа хийдэггүй юм уу. Одоо сүүлдээ шууд Их Хурлын гишүүд рүүгээ хандаад энэ анхаарлаа хандуулаач гээд байх боллоо. Яах гэж засаг захиргааны нэгж байдаг юм. Сум аймаг гэж яах гэж байдаг юм. Яах гэж төрийн захиргааны төв байгууллага байдаг юм. Танайх энэ дээр юу хийж байгаа юм. Тэр Говьсүмбэр аймгийн Эко Сураа гэж компани тэр оршин суугчдын эрүүл орчинд амьдрах эрхийг нь илтээр зөрчөөд тэр Шивээ говийн уурхайг тасалж авсан л нөхдүүд л дээ. Говьсүмбэрийн суурьшлын бүсэд хажууд ухаж байгаа. Энэ дээр яг ямар юу байгаа юм? Хэдийгээр энэ төсвийн тодотголтой холбоогүй ч гэсэн нэгэнт уулзсаных асуугаад авчихъя. Энэ санал байгаа юу. Тэгвэл санал дээр дараагийнх нь би өнгөрсөн 7 хоногт Дорноговь аймгийн Айраг суманд Цагаан дэлийн уурхай орчимд ажилласан. Мөнхбаясгалан гишүүнтэй цуг ажилласан тэр саналуудаа хэлээдэхье. Тэгээд та бүхэн энэ дээрээ нэг жоохон анхаарч ажлаа хийхгүй бол улсын тусгай хамгаалалтад авчхаад юу ч хийгдээгүй байна шүү.

М.Мандхай: Батбаяр дарга хариулт өгье. Нэг номер.

Ш.Батбаяр: Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр. Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа. Онги-Цагаан бургастай төслийн ТЭЗҮ явах ажил явагдаж байгаа. Байгаль орчны үнэлгээний 900 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендер 5 дугаар сарын 31-ний дотор гэрээ байгуулж чадаагүй гэдэг үндэслэлээр ирэх он руу шилжсэн байгаа. Гэрээ байгуулах энэ төсөл маань нэлээн бас нэлээн том зурагтай объёмтой тэгээд нэлээн өндөр түвшний мэргэжлийн байгууллагын шаардлага тавигдаж байгаа гэдэг үүднээс оролцогч компаниуд маань шаардлагыг хангаж чадаагүй байгаа.

Хоёрдугаарт Коп-17 хурлын үеэр нэлээн томоохон бас хөрөнгө оруулалтын амлалтууд хэлэлцээрүүд эхэлсэн байгаа. Жишээлэх юм бол Европын хөрөнгө оруулалтын банкаар 200 сая еврог бас тодорхой хэмжээний энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой ойн салбар руу ч зэрэг шилж одоо хөрөнгө оруулалтууд хийгдсэн байгаа. Нийтдээ энэ газрын доройтол цөлжилттэй тэмцэх асуудалд бол 1.8 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг оруулъя. Сэргээгдэх эрчим хүч дата төв дээр бас нэлээн өндөр хүчин чадал бүхий дата төвийг байгуулахаар яриа хэлэлцээрүүд хийгдэж байгаа. Энэ чиглэлээр бид ирэх 2 жилийн хугацаанд уг хурлыг даргалах улс орны хувьд усны төслүүдээ аль болох тэргүүлэх чиглэлийн төсөл болгож хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажиллахаар байгаа. Ирэх жил, ирэх оны хувьд бол усны чиглэлээр Ганга нуурын бохирдол ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах, хөв цөөрөм байгуулах болон Онги-Цагаан бургастай мөн саяын хэлсэн төслийн мөн ТЭЗҮ зураг төслийг боловсруулах зэрэг ажлуудыг улсын төсөвт оруулахаар ажиллаж байна аа.

М.Мандхай: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Саяын энэ явагдаж арваад хоног хуралдсан энэ Коп чинь цөлжилтийн эсрэг байсан шүү дээ? Яг цөлжилтийн эсрэг. Тэгэхлээр уг нь энэ өндөр зардалтай болсон хурлын чинь яг агуулга зорилгод нь нийцэж л байгаа юм л даа. Сая тэр нэг Европын холбооноос уг нь 2 зуугаад сая евроны асуудал хэлэлцээр хийгдэж байгаа гээд. Тэр чинь дата төв мөв гээд шал өөр тийшээ яваад өгсөн байх юм. Энэ говь руу ус татахад энэ чиглэлийн төслүүдээ яг бэлтгэж өгсөн юм уу гэж би асуугаад байна л даа. Өөрөөр хэлбэл одоо энэ ТЭЗҮ нь бэлэн болчихсон Хэрлэн тонныг ТЭЗҮ-ийнх нь төсөвт тавигдсан байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь яах вэ он дамнаад хийгдэх юм байна. Онги-Цагаан бургастай эд нар чинь явах юм уу л гэж асуугаад байгаа юм.

М.Мандхай: Батбаяр дарга хариулъя.

Ш.Батбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр энэ хурлын гарсан томоохон бодлогын үр дүнгүүдийн нэг бол манай улсаас өргөн барьсан тал хээрийн төлөвлөгөөг дэлхийн 196 улс Европын холбоо оруулсан 197 талууд дэмжиж баталсан байгаа. Энэ тал хээрийн төлөвлөгөөний гол 3 санаачилгын нэг нь усны санаачилга байгаа. Усны санаачилга дотор маань манай бүхий л усны төслүүд 333 сум, нуур, цөөрөм болон бусад усны төслүүд бүгд багтаж орсон байгаа. Тэгэхээр энэ түрүүн хэлсэнчлэн Бага хурлаар үр дүнгээ батлуулсан энэ тал хээрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил маань ирэх 2 жилийн хугацаанд бидний даргалах ажлын маань нэг хэсэг болоод байгаа юм аа.

Миний сая дурдсан Дата төв болон бусад төслүүд бол бүгд өөр өөрийн гэсэн тусдаа санхүүжилттэй байгаа. Тэгээд одоо тэр 200 сая евро дээр жишээ нь бид усны төслүүдийн зарим нэгийг суулгах ч гэдэг юм уу бүхий л талаар хамтарч ажиллахаар байгаа.

М.Мандхай: Би нэг хэдэн асуулт асууя гэж бодож байна. 2021 онд улаан буудай Монгол Улсын нийт энэ элеваторын багтаамж 552 мянган тонн байсан. Үүнийг Засгийн газрын мэдээлэл дээр танилцуулга дээр 2024 он гэхэд 20 мянган тонноор нэмэгдүүлэхэд 40 тэрбум төгрөг шаардагдана гэсэн нэг тоо яваад байсан. Тэгэхээр энэ намар 500 мянган тонн ургац хураана гэж зарласан байна лээ. Тэгэхээр энэ ургацыг бид нар хаана хадгалах вэ? Бүсчилсэн байдлаар багтаамж ургацын харьцааг ер нь гаргаж харж болох уу? Одоо гурилын үйлдвэрүүдийн 364.2 мянган тонн элеватор чинь ер нь энэ өөрсдийнх нь эргэлтийн нөөц байдаг. Одоо хувийнх нь. Тэгэхээр энэ улсын нөөц өөрөө бүрдүүлэхэд ашиглах боломжтой сул багтаамж ер нь яг хэд байгаа юм? Тэгэхээр нийт багтаамжийн 90 хувь нь тариалангийн бүс буюу төвийн бүсэд хамаарна гээд түрүүн сайд бас хэлчихнэ лээ. Тэгэхээр энэ алслагдсан бүсийн тариаланчид ургацаа ер нь хаана хадгалах вэ? Тэгэхээр үндсэндээ Засгийн газрын өөрийнх нь танилцуулахад багтаамжийг 2024-2025 онд 20 мянган тонноор нэмэгдүүлэхэд 40 тэрбум төгрөг шаардагдана гээд заачихсан байгаа тиймээ? Тэгэхээр энэ тодотголын 150 тэрбум дотор энэ агуулахад ноогдох дүн нь яг хэд юм бэ? 40 тэрбум юм уу? Энэ дээр нэг тодорхой нэг тоо зөрөөд байна л даа.

Хоёрдугаарт би нэг юм асуух гэсэн юм. Хүнсний хүнсний хувьсгалын хөдөлгөөний хүрээнд зоорины хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 80 тэрбум төгрөг

зарцуулчихсан байгаа. Тэгэхээр энэ хэдэн тонн багтаамжийг яг бий болгочихсон юм бэ? Өнөөдөр бид нар нэмж ингээд багтаамж яриад байдаг нэмж сав суулгаа нэмэгдүүлэе л гээд яриад байдаг. Өмнө нь зарцуулчихсан байгаа үр дүн чинь ерөөсөө яригдахгүй байгаа байх юм. Бид нар 2021 оныхоо дүнтэй л яваад байх юм. Гэтэл энэ чинь 40 тэрбум төгрөгийг 2024 онд зарцуулаад 20 мянган тонн багтаамжийг нэмэгдүүлчихсэн байх ёстой байгаа. Хүнсний хувьсгалын хүрээнд 80 тэрбум төгрөгөө зарцуулчихсан. Тэрний үр дүн хаана явж байгаа юм. Тэрийгээ нэг тодорхой нэг хэлээд өгөөч.

Тэгэхээр хэрэв бид нар 80 тэрбум төгрөг зарцуулсан байгаа юм бол Засгийн газрын энэ өөрийн үнэлгээгээр 20 мянган тонн чинь 40 тэрбум юм бол 40 мянган тонн багтаамж нэмэгдсэн байх ёстой гэдэг тооцоолол гарахаар харагдаад байгаа юм. Тэгээд энэ яг бодитой нэмэгдсэн юм уу? 20 мянган тонн махыг Улаанбаатар хотын ойролцоогоор 1 сарын хэрэглээ. Би өчигдөр бас чуулган дээр энэ асуудлыг ярьж байсан.

Улсын хэмжээнд энэ 2, 3 долоо хоногийн хангамж байна аа. Өнөөдөр бид нар махны энэ үнэ инфляц улам нэмэгдэхээр дүр төрхтэй харагдаж байгаа. Одоо нэгэнт цалин хөлс нэмж л байгаа бол дагаад л инфляц нэмэгдэнэ. Тэгээд энэ дээр бид нар яг ямар зохицуулалт хийх юм бэ? Ер нь энэ 20 мянган тонн махыг нөөцөлнө гэдэг ямар логик үндэслэлтэй тоог гаргаж ирсэн юм бэ гэдгийг би асуумаар байгаад байгаа юм. Яагаад 20 мянган тонн юм бэ? Энэ өөрөө үнийг тогтворжуулахад зарцуулж байгаа юм уу? Ямар зориулалтаар энэ 20 мянган тонныг гаргаж ирсэн юм бэ? Яагаад гэхээр одоо энэ мах 13 хувийн инфляцтай. 4.7 нэгжийг дангаараа бүрдүүлж байгаа гээд сая Эдийн засаг хөгжлийн яамны дарга ярилаа.

Тэгэхээр энэ үнэ бол үндсэндээ 50 гаруй хувиар өсчихсөн. Тэгээд энэ 20 мянган тонн чинь 3 долоо хоногийн нөөц үнийг бид нар ер нь яаж тогтворжуулах гэж байгаа юм. Энэ үнэд үзүүлэх ер нь нөлөөллийн тооцоо энэ тэр гаргаж харсан юм болов уу? Бид нар 20 мянган тонн махыг килограмм тутамд ер нь хэдээр худалдан авахаар төлөвлөсөн байгаа юм бэ? Энэ бөөний үнэтэй харьцуулж ер нь гаргаж ирсэн үү гэдэг энэ нэг тооцоог асууя. Тэгээд ер нь бодлогын яам, Эдийн засаг, хөгжлийн яам миний л бодлоор би эдийн засаг сурч байхад энэ чинь орлогынхоо түвшнээр инфляцыг тодорхойлоод яг тухайн тэр зорилтот бүлэгт чиглэсэн стратегийн нөөцийг бүрдүүлэх гэж байгаа бол ямар түвшинд энд стратегийн нөөцийг тооцож бүрдүүлэх юм. Ямар аргачлалаар зорилтот бүлгүүддээ хүргэх юм гээд ийм түвшинд бодлого боловсруулаад төсвөө тодорхойлж оруулж байх ёстой гэж би хараад байгаа юм.

Гэтэл ингээд ямар ч ийм харьцангуй ийм бодлого нь тодорхойгүй үнээ тогтворжуулахад ийм дорвитой хариу өгч чадахгүй. Энэ тоонууд нь хоорондоо логик ямар ч мөргөлдөөн байхгүй өмнөх зарцуулсан төсвийнхөө үр дүнгээ хүртэл ингэж тайлбарлаж тайлагнаж чадахгүй ийм түвшинд л бид нар ер нь төсөв хэлэлцээд байгаа шүү. Энэ дээр тэгээд түрүүний тодорхой яг асуулт асуусан тэгээд тодорхой хариулт авъя аа.

Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Монгол Улсын төрөөс ХХАА-н салбар дээр бас маш том дэмжлэгүүд бодлогын том бичиг баримтууд баталж түүнийгээ хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Энэ бол 3 сая 500 мянган хүний хоол ундтай холбоотой асуудал. Нөгөө талдаа энэ дэмжлэгүүд зарим үед энэ байгаль цаг уурын энэ нөхцөл байдал олон

хүндрэлүүдийг бас давж гардаг. Яг одоо ингээд тариалангийн бүс нутагт очоод энэ яг баялаг бүтээж байгаа хүмүүстэй ингээд уулзахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж эхэлсэн энэ хүнсний хувьсгал бас тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн шүү гэдэг зүйлийг энэ тариалан эрхлэгч нар хэлдэг. Үүний хүчинд бид нар энэ комбайныг авсан, үүний хүчинд энэ үтрэмийг барьсан шүү гэдэг. Тэгэхээр энэ бас тодорхой хэмжээнд өнөөдөр бид нар дотоодынхоо хэрэгцээг 100 хувь хангаж байна гэж ингэж яриад сууж байгаагийн бас нэг том юу болно оо, үр дүн болно оо гэж ингэж харж байгаа.

Тодорхой асуултуудад хариулъя. Элеватор 100 мянган тонныг хадгалах сав байна уу гэж. ХАА-н корпорац Монгол Улсын хэмжээнд тариалангийн бүс нутаг зүүнээсээ баруун хүртлээ 7 цэг дээр энэ 100 мянган тонн улаан буудайг стандартын шаардлага хангасан сав агуулахад авах нөөц бололцоо байна. Бидэнд 182 мянган тонн улаан буудай хадгалах сав бэлэн байна одоо яг ХАА-н корпорац дээр. 100000-ыг нь авна, 60 мянгыг нь бараг түрээслээд болох ийм ч бололцоо бас байгаа. Энийг ч ААН-үүд бас ашигласаар ирсэн юм билээ. Нөгөө талдаа сая ингээд тариалангийн бүс нутгаар явж байхад Эм Ти Эс компани бол энэ комбайныг авсан Жон Дэри билүү энэ элеватор буюу нөгөө нэг бид нарын үздэг мартагдашгүй намар кинон дээр гардаг байсан тэр үтрэмийг ийм болгочихсон юм гээд ингээд яриад сууж байгаа ийм жишээнүүд маш их байна лээ.

Харин цаашдаа бид нар энэ Монгол Улсад энэ үтрэмийн аж ахуйг өшөө хөгжүүлмээр юм байна лээ. Энэ тариалангийн талбайнаас үтрэм дээр буугаад үтрэм дээр шувуу тоншоод дээрээс нь тэгээд цан өвөл болоод ингээд нөгөө нэг мартагдашгүй намар кино шиг ингэж ингэж явсаар байгаад бараг ингээд 20 хувиа алдчихвал алдчихдаг шүү дээ. 15-аас 20 хувиа. Тэгэхээр тийм алдагдалд орохгүйн тулд ер нь том жижиггүй яг хэм хэмжээндээ таарсан үтрэмтэй болох ёстой юм байна гэж. Тэгээд үтрэмийг цаашаа хөгжүүлнэ гэж ингэж бодож байгаа. 20 мянган тонн махны асуудал дээр яах вэ би хэлээд байгаа, хэлсэн. Ер нь тийм ч сайн арга биш. Тэгэхдээ л арваад жил яваад ирлээ сайн муу хэлэгдэн барин. Энэ жилийн хувьд шинэ зохион байгуулалтад ороход 1 дүгээрт эрсдэл өндөр байна.

Хоёрдугаарт цаг хугацаа байсангүй. Тийм учраас уламжлалтаараа явъя. Гэхдээ нэг шинэ юм оруулж ирээд мах авна гээд зээл, маш хөнгөлөлттэй зээл авсан бол мах л болдог тэр хяналтын системийг Санхүүгийн үндэсний төв УТҮГ и баримтаар нь.

М.Мандхай: Гүйцээж хариулах уу?

М.Мандхай: Хянаад явчихъя гэж байгаа юм. Тэгэхээр ингэхээр нөгөө нэг бид нарын хөнгөлөлттэй зээл өгсөн ААН-үүд мах авъя гээд машин авчхаж чадахгүй л гэсэн үг. Эсвэл хямд мах аваад эргүүлээд Дэнжийн мянга дээр үнэтэй болохоор аваачаад зарчихдаг шиг тийм бусармаг юм гарахгүй гэсэн үг.

Тэгэхээр бид бол энэ махны энэ чинь 2 сая хүний энэ Улаанбаатар хотын 1 сая 600, 700 мянган хүний бүх жилийнх нь хэрэгцээг хямд махаар хангах гээд байгаа юм биш шүү дээ. Яг мах өсдөг цагаан сарын ард дээр 3 сарын 15-аас 6 сарын 15 хүртэл буюу энэ 3 сар цаашилбал нэг наадам дөхүүлчих юмсан гэсэн ийм л зорилго байгаа. Бусад цаг үед бол зах зээлийнхээ зарчмаар л явна. Энэ мал махтай болгож байгаа энэ 300 мянган малчны асуудал бас энэний цаана давхар яригдана.

Тийм учраас энэ нэг аль аль талдаа нэг малчдаа ч хохироочихгүй юм сан. Энэ инфляцад сөрөг нөлөө үзүүлээд байгаа 4.7 хувийг эзлээд байгаа энэ махны үнэ өсөөд байгаа тэр хаварт нь бас нэг жоохон интервенц хийчих юмсан. Ийм л зорилготой юм болохоос биш бүгдээрээ нэг их.

М.Мандхай: Яах вэ одоо байгаа багтаамж дүүрчихсэн. Тэгээд бид нар 40 тэрбум төгрөгөө одоо үндсэндээ 20 мянган тонн болгож нэмэгдүүлэхэд зарцуулна гээд Засгийн газарт угаасаа танилцуулга байгаа. Зүгээр ер нь бол энэ 40 тэрбум төгрөгийн агуулахад агуулгатай явах юм бол үлдэх 150-аас 110 тэрбумаар 132 мянган тонн үндсэндээ мах буудайн хүнсний ногоо худалдан авахад килограмм тутамд 833 төгрөг ноогдож байгаа.

Тэгэхээр ер нь бид нар аливаа төлөвлөгөөг гаргахдаа эргээд энэ чинь өөрөө төсвийн мөнгө биш, энэ чинь зээл байгаа учраас бид нар худалдан авах үнийн бүтээгдэхүүн тус бүрээр нь тооцож гаргадаг байх ёстой. Тийм түвшинд бид нар хариулдаг байх ёстой. Өнөөдөр 150 тэрбум төгрөгийн худалдан авалтад хүрэлцэхгүй байх юм бол тэр мөнгө худалдан авалт биш юм аа. Яагаад гэхээр зээлийн эх үүсвэр, төр зээлдүүлж байгаа компани худалдаж авна тэгвэл энэ нөөц нь өөрөө төрийн өмч биш компанийн өмч болчихож байгаа юм. Хүүгийн татаас 150 тэрбум нь өөрөө зээлийн хүүг хөнгөлөх зардал байгаа. Энэ удаад бүүр зээлийн хүү болгож орж ирж байгаа. Яг түрүүний хүнсний хувьсгалын 80 тэрбум төгрөг бас л адилхан зээлийн хүү. Одоо ингээд хэдүүлээ нэг ийм тэнд нэг тийм комбайн авсан байна лээ. Тэнд нэг үтрэмийн нэг ийм аятайхан тоног төхөөрөмж авсан байна лээ гэдэг ийм тоо хэмжээгүй асуудал ярихаа больё оо. Мөнгө зарцуулсан нь үнэн. Зарцуулсан чинь үр дүн бичнэ шүү дээ. Тодорхой ярь л даа энэ чинь зээлийн хүү шүү дээ. Тэр зээлийг төлөөгүй бол яах юм. Тэнд 2 компани тэгвэл бодитой ажил хийгээд бусад компаниуд нь бодитой ажил хийгээгүй байвал яах юм. Хэн хариуцлага тооцох юм. Тэгээд үр дүнгээ ярь гэхээр яг тодорхой энэ мөнгийг зарцуулсан. Бид нар ийм зорилт тавьсан өнөөдрийн багтаамж тэдэн хувиар нэмэгдээд тэдэн тонн болсон юм гэдэг ийм тодорхой тоо л ярь л даа. Тэгээд энэ эргэлтийн санхүүжилт нь яах юм.

Худалдан авалт буцаад борлуулагдах юм уу. Үгүй ийм тодорхой тоо ярихгүй болохоор чинь ерөөсөө ойлгоно. Тэрнээс биш би та нарыг яг үнэнээ хэлэхэд ингээд Ерөнхийлөгчийн санаачилга гэдэг Ерөнхийлөгчийг битгий энд татаж оруулж ирээд бай. Энэ санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлж чадсан юм уу гэдэг дээр Засгийн газар хариуцлага хүлээх ёстой. Тэр 80 тэрбум төгрөг зарцуулаад хэдэн төгрөгөөр үндсэндээ энэ тонноор нэмэгдсэн юм, багтаамж нь хэдээр нэмэгдсэн юм. Энэ нь өнөөдрийн гаргаж байгаа ургац тариалалтын хэдэн хувийг хангаад байгаа юм. Одоо тэгээд 150 тэрбумдаа бид нар авч байгаа нь хэдээр энэ улс чинь багтаамжаа нэмэгдүүлж чадаж байгаа юм бэ гэдэг ийм бодитой тоо. Энийгээ эргээд бид нар нэгж үнэ дээр хуваахад хэдээр төлж чадахаар байгаа юм. Энэ үр дүнтэй хөрөнгө оруулалт болж чадах юм уу, чадахгүй юм уу гэдэг ийм хэмжигдэхүйц үзүүлэлтээр хариултаа авмаар байна аа.

Идэрбат гишүүн хариулъя.

Ц.Идэрбат: 150 тэрбум төгрөгийн зардлыг би задаргааг хэлсэн. Улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэлт нь 80.7 тэрбум төгрөг. Энэ дээр манай ХАА-н корпорац дээр байгаа 55 орчим тэрбум төгрөг нийлээд үндсэндээ 100 мянган тонн улаан буудай бид нар хадгална. Энэ нь Монгол Улсын гурилын хэрэгцээний шаардлагатай улаан буудайны 3/1. Одоо бол бид нар 320 мянган тонн улаан буудай

хэрэглэдэг. Тэгээд яаж бүгдээрээ энэ 100 хувь хангах гээд байгаа юм гэхээр энэ гурилын үйлдвэрүүд өөрсдийнхөө хөрөнгөөр 100000-ыг энэ 9 үйлдвэр л худалдаж авна. Үлдсэн 100000-ыг нь бид нар авахад нь зориулж хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Үүний татаас нь 3.9 тэрбум төгрөг болно. Ингэж байж Монголчууд яг дотооддоо үйлдвэрлэсэн тарьсан улаан буудайгаараа үйлдвэрлэсэн гурилаа хоол хүнсээ хийж иднэ. Үүний үр дүнд юу байх вэ гэхээр газар тариалангийн энэ салбар бас ч гэж тодорхой хэмжээнд санхүүгийн чадавх.

М.Мандхай: Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Ганбаатар гишүүний асуултад гүйцээж хариулъя. Нэг номер.

Ш.Батбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Байгаль орчны яамны дэргэдэх салбарын хяналтын газраас Говьсүмбэр аймагт ажиллаад агаарын чанарын шинжилгээг аваад лабораторид хүргүүлсэн байгаа. Тэгээд уг шинжилгээний хариу гарсны дараа бид холбогдох арга хэмжээг авахаар ажиллаж байгаа. Иргэдээс маш их хэмжээний гомдол ирсэн. Яг амьдарч байгаа бүс нутагт нь бас онцгой үнэр гарч байна. Түүнтэй холбоотой толгой өвдсөн, хоолой бачуурсан гэдэг гомдлууд ирсэнтэй холбоотой. Бид шуурхай баг гаргаж ажилласан байгаа.

М.Мандхай: Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Замира гишүүнээр тасаллаа. Сонгобайн Замира гишүүний микрофоныг.

С.Замира: Махны үнийг ярихаар нөгөө малчдын талаар юм гарах юм. Малчдын талаар ярихад энэ махны үнэ өссөнд малчид ямар ч холбоогүй шүү дээ. Энэ өссөн их махны зөрүү хаана унаж байна гэвэл ченж нарын карманд л унаад байна. Тэр ченж нарын ард нь хэн байгаа гэдэг дээр ер нь манай улс нэг хяналтаа хийгээд нэг тодорхой дүгнэлт гаргах ёстой. Шууд худалдан авалт хийх тал дээр ажиллах хэрэгтэй. Төр тэрнийг зохицуулах л ёстой. Ченж дамжсан нь бүх юмны үнэ нь өсөөд байна шүү дээ. Махны үнэ өсөөд байна. Валютын үнэ нь өсөөд байна. Тэгэхээр одоо яг малчид махны үнэ ярихаар, махны үнэ буулгана гэхээр малчид хохирно гээд ярьж байгаа нь буруу. Энэ тал дээр бас ХААЯ анхааралдаа авна биз дээ. Тэгээд баруун бүс гурил ингээд төв зүүн юун дээр Монгол Улсын тариа тарьж авдаг л даа төв дээр. Баруун бүс бараг тариалан байхгүй тэгсэн мөртөө гурил буудайг энд мянга хэдэн зуун км-ээс зөөдөг юм.

Сая нөгөө Эдийн засаг, хөгжлийн яамны хүмүүсийн хэлснээр худалдан авалт 4.9 хувиар бараг хасах руу орсон. Энэ дээр дүгнэлт хийх хэрэгтэй байхгүй юу бид нар. Тайлбар яриад махны үнэ ихэсвэл малчин нь хохирно, хэрвээ баруун бүсээс гаалийн татварыг нь тэглээд гурил буудаг оруулбал гурилын компани дампуурна гээд тийм биш шүү дээ. Төвд байгаа гурил хэрвээ илүү гараад байх юм бол экспортод гаргаж болно шүү дээ. Ойрхон газарт тохиролцож болно шүү дээ, хойд хөрштэй. Тэгээд баруун бүсээс нь гаалийн татварыг гурил будааг баруун бүсийн аймгуудад оруулж хангах тал дээр арга хэмжээ авах ёстой байхгүй юу. Нэг цээжилсэн хэдэн үгээ яриад суугаад байдаг, суугаад байдаг, ямар ч нэг авсан бодит арга хэмжээ байхгүй. Ард түмэн нь хасах руу орсон гэж өөрсдөд нь яриад байдаг. Цалин хөлс нь нэмэгдэхгүй бүх юм нь нэмэгдээд байдаг. Энэ 2 тал дээр ер нь та нар анхаарал тавьж тэр баруун бүсийн гаалийн татварыг тэглэсэн асуудал 4 сарын 1-ээс дахиад гаалийн татвартай болж эхэлсэн. Тэрний эргэж гараад баруун бүсийг гурил будааны гаалийн татваргүй болгоод тэгээд малчдын малыг яг малчдын гараас аваач гэдэг хүсэлт тавимаар байна. Тэр хувийн компани нь байна уу,

хувьсгалын компани нь байна уу? Ченж дамжуулаад бүх юм нь өсөөд байна. Малчин биш хохирч байгаа ченж нар хожоод байна. Энэ тал дээр анхаараач гээд засаг төрд яамдуудад нэг анхааруулмаар байна даа. Баруун бүсийн гаалийн татварыг нэг эргэж харж та нар дахиад тэглэхийг бодоорой. Баярлалаа.

М.Мандхай: Ганбаатар гишүүн миний микрофоныг нээе.

Г.Ганбаатар: Одоо яах вэ дээ ингээд төсвийн тодотгол ингээд л Байнгын хороодоо дамнаад л явна л даа. Ер нь нийгэмд ингээд гарч байгаа юм юу гэхлээр энэ АН л ялангуяа энэ өчигдөр ч гэсэн намайг ингээд нэг тэтгэвэр цалин, нэмэхийг эсэргүүцээд байгаа юм шиг. Эсэргүүцээд байгаа юм ерөөсөө байхгүй шүү дээ. Хамгийн гол нь яг бодитой зардлын хэмнэлт гарч байна уу үгүй юу? Саяын энэ 1.4 их наядыг ингээд л хэмнэсэн гээд л яриад байна. Гэтэл энэ чинь ингээд нарийн ингээд бүгдийг нь ингээд задлаад үзэхлээр 700 гаран тэрбум нь тэр тусмаа бас энэ саяын өнөөдрийн яригдаад байгаа ингээд сайд нарын зардлаас бас нэг 433 тэрбум л тэгээд бодитой байгаа байхгүй юу. Тэгээд ингээд зардал хэмнээгүй байж байж ингээд ахиад зардлаа нэмүүлж орж ирээд байхлаар чинь энэ зах зээл рүү ямар ч нэмүү өртөг шингээгүй ямар ч бүтээмжгүй ийм мөнгийг хүчээр цутгаад тэгээд ингээд тэтгэвэр, цалин нэмээд байхаар чинь үндсэндээ тэр чинь нэмэгдэл биш болчхоод байгаа байхгүй юу. Ахиад л инфляц өдөөгөө л. Хамгийн гол зүйл бид нар энэ тодотголоор юу хүсэж байсан бэ гэхээр бодитойгоор зардлаа хасчхаасай гэж хүсэж байсан юм.

Дээрээс нь энэ 220, 230 мянга хүрээд байгаа энэ төрийн албан хаагчдаа нэг зоригтойнх нь цомхотгоод энэ Ерөнхий сайдыг нэг цомхотгоод ороод ирэх болов уу, бас залуу хүн дорвитойхон шинэчлэл хийчих болов уу. Тэгсэн бол нөгөө захад нь, нөгөө талд чинь хөдөлмөрийн зах зээл дээр маш их эрэлт байна шүү дээ. Хувийн хэвшилд ажиллах хүнгүй хүнгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэр рүүгээ нийлүүлээд.

Дээрээс нь энэ зардлуудаа бодитой байсан бол энэ жинхэнэ бодитой нэмэгдэл болох байсан юм аа. Тэгээд одоо яах вэ тэгээд цалин, тэтгэвэр нэмээд төрийн албан хаагчийнхаа цалинг нэмээд ахиад л инфляц өдөгдөөд л явах байх.

Энэ яах вэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооныхоо хурал дээр байгаа учраас түрүүн тэр байгаль орчны төрийн нарийн яах вэ танайхаас тэр нэг юу хийсэн юм байна? Шинжилгээ хийсэн юм байна агаар, орчны. Яаралтай тэр дүнгээ явуулаарай, иргэдэд хүргээрэй. Одоо бүүр сүүлдээ утас чат амраахаа байлаа. Ялангуяа Говьсүмбэр аймгийн иргэдийн бухимдаад байгаа нь буруу биш байхгүй юу. Энэ чинь аль 2, 3 сарын өмнөөс эхэлсэн асуудал.

Дээрээс нь танай салбарын сайд руу чинь өчигдөр би албан тоот явуулсан байгаа. Яг тэр хүрээнд буцаагаад үнэхээрийн хүний иргэдийн тэр амьдрах орчинд нөлөөлж байгаа юм уу, яг ямар хор тэр орой үдэш унтуулахгүй тархи толгойг нь өвтгөөд байгаа юм гэдэг асуудал байгаа. Тэр Дорноговийн Айраг сумын тэр Цагаан дэлийн усыг нь тусгай хамгаалалтад авсан шүү дээ. Өнгөрсөн жилийн 2025 оны 9 сард Засгийн газар нөгөө юуг нь тогтоосон хил хязгаарыг нь. Тэнд ерөөсөө хийгдсэн ажил алга байна. Тэр хавийн уул уурхайнууд 9 уул уурхай усыг дураараа орон нутгийн иргэдийн эрх мэдэл хүрэхгүй орон нутгийн удирдлагуудын эрх мэдэл нь хүрэхгүй байна. Улсын байцаагч тэнд алга байна. Тэгээд тэр байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийнх нь үнэлгээ нөгөө нарийвчилсан үнэлгээнүүд нь яаж хийгдсэн

юм, тэр мэргий ч гэдэг юм уу мэдээллүүд хэрэгтэй байна. Тэгээд би албан тоотоор хандчихъя. Надад хариуг нь яаралтайхан өгчхөөрэй. Тийм саналууд байна аа.

М.Мандхай: Алтангэрэл гишүүн үгээ хэлье.

О.Алтангэрэл: Манай ХАА-н сайдын дэвшүүлээд байгаа бодлого зүйлүүд зөв зүйтэй юм зөндөө байгаа юм аа. Тэгэхдээ анхаарууштай юмнууд бас байна аа. Идэрбат сайд ээ. 2002-2023 онд Монгол Улс 7858 тонн нөөцийн мах бэлтгэсэн юм билээ. Тэгэнгүүтээ тэрнийхээ 5369 тонныг нь борлуулсан байгаа байхгүй юу. Энэ бол ерөөсөө сүүлийн 4 жил 4, 5 жилийн хугацаанд хамгийн өндөр бэлтгэж байсан нь энэ. Тэгэнгүүт энэ жил та бүхэн маань 20 мянган тонн гэж оруулж ирж байгаа байхгүй юу. Сүүлийн 5 жилийн хамгийн их үнийн дүнгээс 3 дахин ихийг гээд заавал ингэх хэрэг байгаа юм уу. Үндсэндээ 4 жилийн өмнө 7 мянгыг бэлдээд л үлдэж байсан байна шүү дээ. Тэгэхээр одоо тэрнээс хойш хүн амын тоо нэмэгдлээ нэмэгдлээ гээд ийм хэрэгцээ байгаа юм уу.

Тэгэхээр бол энэ судалгаагаа бас нэг эргэж хараарай та бүхэн маань эргэж хараарай. Тэгээд энэ малыг эрүүлжүүлэх одоо тэр вакциныг дотооддоо савлах таны энэ ярьж байгаа зүйлүүд бүгдээрээ зөв шүү. Түрүүний тэр үтрэмийн аж ахуйг хөгжүүлнэ гэж байгаа чинь зөв шүү. Тэгэхээр эндээс гарч байгаа зөрүү гэдэг юм уу төсөв мөнгө хөрөнгөө энэ зүг рүүгээ чиглүүлэх тэр зүйлээ бодоорой. Вакцины асуудал сая чухал байна. Та түрүүн ярьж байна. Дундговь аймгийн хойд хэсэг, Өвөрхангай аймгийн урд хэсэг Өвөрхангай аймаг бол ерөөсөө маш их шүлхий тархсан. Тэгээд вакцины асуудалтай байсан. Вакцины тендер нь худалдан авах ажиллагааны газар зарлагдаад явж байсан тэр цуцлагдаад. Та бүхэн маань өөр төрлийн шүлхий гарлаа гээд тэгээд тэр зүг рүүгээ ингээд анхаарал хандуулаад явчих шиг боллоо. Өөр хүрээний өөр төрлийн тийм тийм тэгээд зэрэг гарчихсан учраас тэр зүг рүүгээ аргагүй шаардлага гарах шиг боллоо. Тэгэхдээ ер нь энэ малаа эрүүлжүүлэх зүг рүү хэдүүлээ анхаарлаа тавихгүй бол малчид малаа борлуулахад, хотынхон эрүүл мах идэхэд энэ нэлээн хүндрэлтэй байна шүү. Төсөв мөнгө гарч болдог л юм мал эмнэлгийнхээ салбар луу хиймээр байна аа.

Өнөөдөр бид нар сошиал орчинд иргэд маань мах худалдаж авлаа дотроос нь ийм идээ буглаа гарлаа гэдэг зураг байнга л харж байгаа. Малчид асуудал гараад мал өвдөөд ирэх юм бол яаж эмчлэх вэ гээд аргаа барж байна шүү дээ. Шүлхийг яаж эмчилж байна гэхээр ундааны сав тайраад, бензин хийгээд, хөлийг нь дүрээд, амыг нь ангайлгаад, хэлийг нь хусаад ингээд механик аргаар малчид тэмцэж байгаа байхгүй юу. Энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр мал эмнэлгийн салбараа бид нар хөгжүүлнэ. Мал эмнэлгийн салбар хөгжүүлбэл мал эрүүл. Тэр махыг хэрэглэж байгаа Улаанбаатар хотынхон төв сууриныхан эрүүл, экспортод гарах нь нэмэгдэх юм бол бас орлоготой л гэсэн үг байгаа юм аа.

Тэгэхээр ингэж их урьд өмнө нь байгаагүй хэмжээгээр тэр нөгөө махны үнэ асуудал нөлөөлсөн байх. Махны үнэ бол хотын даргыг огцроход хүртэл нөлөөлдөг юм байна лээ. Тэгэхээр тэр нөлөө улс төрийн нөлөө нь байсан байх. Тэгэхдээ 4 жилийн өмнөхөөсөө 3 дахин ихийг бэлдэнэ гэж байгаа. Хэмжээгээ та бүхэн маань яг нарийн тооцоо судалгаатай бас хараасай дахиж нэг харж үзээсэй. Энэ чинь бас бас хэтэрхий их байна шүү. Сая гаран толгой хонь гэдэг чинь бас их хэмжээ шүү гэж. Хонин толгойд хөрвүүлэхээр тийм болоод байх шиг байна лээ л дээ.

Тэгэхээр хэтэрхий их хэмнэж байна шүү гэдгийг бас сануулж хэлье ээ. Баярлалаа.

М.Мандхай: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Засгийн газраас төсвийн тодотгол оруулж ирэхдээ 1 их наяд 152 тэрбум төгрөгөөр урсгал зардлыг нэмэгдүүлээд оруулаад ирсэн. Тэгсэн хэрнээ яах вэ бид нар 1.4 их наяд төгрөгийн хэмнэлт хийлээ гээд сурталчилгаа хийгээд байгаа. Тэгэхээр яг бодит хэрэгтээ урсгал зардал 1 их наяд 152 тэрбумаар нэмэгдсэн. Энэ юунд нэмэгдээд байгаа вэ гэхлээр тэр дунд нь энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бас харьяалах асуудалд хамааралтай энэ 150 тэрбум төгрөгөөр мах, хүнсний ногооны, улаан буудайн нөөц бэлтгэх энэ асуудал ороод ирчихсэн байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол энэ ХХАА-н салбарт маш их хэмжээний татаас хөнгөлөлттэй зээл олгож байсан асуудлууд байгаа. Үр дүнтэй нь ч байна, маш үр дүн муутай нь ч байна. Тэгээд энэ чиглэлээр манай Мандхай дарга бас сонсгол ерөнхий хяналтын сонсгол хийнэ гээд энэ сарын сүүлээр болно гэж ойлгож байгаа.

Тэгэхээр бид нар бол янз бүрийн аргаар энэ ХАА-н салбартаа татаасуудыг олгож ирсэн. Тэгээд дийлэнх нь ерөөсөө байгаа оноогүй. Тэгээд ийм нөхцөл байдал ийм байхад дахиад 150 тэрбум төгрөгөөр интервенц хийнэ гэдэг бол бас дахиад л эдийн засгийнхаа зах зээлийн тогтолцоогоо эвдэх, магадгүй дахиад л ямар ч үр дүнгүйгээр энэ зарим бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдүүлэх ийм л нөхцөл байдал руу дагуулах юм гэдэг болгоомжлол бас надад ч гэсэн бусад гишүүдийн адил байна аа. Тэгэхээр энэ 150 тэрбум төгрөгийн тооцоо судалгаа нь маш ойлгомжгүй байна аа. Тэгээд бид нар махны нөөц бэлдэнэ л гээд байгаа. Тэгээд сая гишүүд маань бас хэлж байна. Дөнгөж сая Ерөнхий сайд томилогдсон даруйдаа л нөгөө өмнөх жилийн махны нөөц алга болчихлоо, би хайж байна, гомдож байна гээд л яваад байсан биз дээ. Тэгээд хүмүүст хариуцлага тооцож байна гээд л яваад байсан. Бид нар энэ нөөцөө бэлдэхдээ эргээд нөгөө зах зээлд нийлүүлж байгаа ер нь энэ зах зээлийнхээ голдирлоор ер нь явуулж чадахгүй байгаад байна шүү дээ.

Тийм ч учраас мах хомсдоод үнэд ороод байна аа. Тэгэхээр бид нар аль болох энэ зах зээлийнхээ механизмыг ашигламаар байна. Тэгээд илүү юу гэдэг юм бүтээлч санал санаачилгуудыг гаргамаар байна аа. Тэгээд тухайлах юм бол ХХАА-н сайдад нэг санаа өгье гэж бодоод байна. Төр энэ махыг нөөцөлж нөөцийн сав барьж дээрээс нь ахиад ингэж худалдан авалт хийж ингэж байхын дор бол энэ идэшний зээл олгох асуудлыг бараг арилжааны банкнуудтайгаа шийдээд тэгээд манай айл өрх болгон өөрсдөө энэ намар нядалгааны цаг эхэлж байна. Өөрсдөө идшээ бэлдмээр байна тийм. Эс бөгөөс төр заавал ингээд л бүх юмыг нөөцлөөд л тэгээд тэр нь хаана ч хадгалагдах юм. Яах юм, ийх юм. Өмнөх хугацаанд ямар алдаа дутагдлууд гарч байлаа? Тэгэхээр иймэрхүү жоохон бүтээлч аргаар асуудалд хандмаар байна. Тэгээд энэ 150 тэрбум төгрөг дээр бол үнэхээр асуудалтай байна. Угаасаа урсгал зардал элдэв янз бүрийн энэ хөнгөлөлттэй зээл тусламж татаасуудыг зогсоо гэж байгаа. Тэгэхээр энэ нөхцөлд та бүхэн маань ингэж ийм асуудал оруулж ирээд байгаа дээр миний хувьд бол маш их шүүмжлэлтэй хандаж байна аа. Тэгээд манай улс бол МАА-н орон, ХАА-н орон. Манай малчид ажлаа хийж байгаа, тариаланчид ажлаа хийж байгаа. Хамгийн гол нь төр хэтэрхий их оролцоод дундуур нь янз бүрийн асуудал үүсгээд л тэгээд л нөгөө хотынх нь малчдадаа дургүй, малчид нь хотынхондоо гомдоод л ийм л нөхцөл байдлыг бид нар өөрсдөө үүсгээд байна шүү дээ.

Тэгэхээр дараа дараачийн хэлэлцүүлгүүд дээр энэ сонсгол маань ч гэсэн бас явчихна. Тэгэхээр энэ татаасны энэ нөөцийн асуудал дээр хэдүүлээ л эргэж харах нь зүйтэй байх гэж бодож байна шүү.

М.Мандхай: Гишүүддээ баярлалаа.

Төсвийн төслүүдийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

15.30 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА